



ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЖ СУРВАЛЖЛАХДАА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧМЫГ МӨРДӨХ НЬ

(Сэтгүүлч, редакторуудад зориулсан гарын авлага)

Улаанбаатар хот

2023 он

**ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЖ
СУРВАЛЖЛАХДАА ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧМЫГ
МӨРДӨХ НЬ**

(Сэтгүүлч, редакторуудад зориулсан гарын
авлага)

Улаанбаатар хот

2023 он

Гарчиг

Өмнөх үг	3
Бүлэг 1. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 4-р заалт “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана”-ыг тайлбарлах нь	4
Бүлэг 2. Жендэрт суурилсан хүчирхийллийг ёс зүйтэй сурвалжлах зөвлөмж ...	16
Бүлэг 3. Гэмт хэргийн мэдээний гэрэл зургийг ёс зүйтэй авах, түгээх зөвлөмж ...	34
Бүлэг 4. Хүүхэдтэй холбоотой мэдээллийг ёс зүйтэй мэдээлж сурвалжлах арга зүй	40
Бүлэг 5. Согтууруулах ундаа болон электрон тамхины тухай сурвалжлахад анхаарах зүйлс	48
Хавсралт: Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	56

Өмнөх үг

Хэвлэл мэдээлэл ямар ч цаг үед мэргэжлийн үүргээ ухамсарлаж, олон нийтийн мэдэх эрхийн төлөө хичээнгүйлэн ажилласаар ирсэн. Үймээн самуун, жагсаал цуглаан, цар тахал, байгалийн гамшиг, ослын хүнд үед ч сэтгүүлчид мэдээллийг хүргэсээр байдаг. Тэр хэрээр сэтгүүлчид эрсдэлтэй нөхцөлд ажилладаг. Энэ үед мэргэжлийн ёс зүйн зарчмаа баримтлах нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн хариуцлагыг нэмэгдүүлж, учирч болох аливаа алдаанаас хамгаалдаг билээ.

Энэхүү гарын авлагад осол гамшиг, гэмт хэрэг, жагсаал цуглааны үед сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллээ бэлтгэхдээ ёс зүйг хэрхэн мөрдөх тухай болон ёс зүйн өндөр мэдрэмж шаарддаг зарим сэдвийг, тухайлбал, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээлэл, хүүхдийн тухай, согтууруулах ундаа, тамхины хэрэглээний хор хөнөөлийн талаар хөндөхдөө анхаарах зүйлсийн талаарх зөвлөмжийг багтаалаа.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дөрөвдүгээр заалтад “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана” хэмээсэн байдаг. Энэхүү заалт нь дотроо зургаан зүйлтэй. Тодруулбал, гамшиг, осол, гэмт хэргийн тухай мэдээлэхдээ хүүхэд өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөхийг магадлах, үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэх, шүүхээр гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй байх зэрэг зүйлийг тусгасан байдаг. /Жич: Энэхүү гарын авлагыг боловсруулан бэлдэж байх үед ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмуудыг сайжруулан боловсруулж байсан бөгөөд энд дурдагдаж буй дөрөвдүгээр заалт шинэчлэгдэн өөрчлөгдсөн байх магадлалтайг нягтлан үзнэ үү/

Түүнчлэн энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон ХМЗ-ийн хараат бус зөвлөх Д.Нарантуяа, ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүн, Peak.mn сайтын эрхлэгч Ц.Цэрэндолгор, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Батбаатар, Хэвлэл мэдээллийн гэрэл зураг, шууд дамжуулалтын МРА. mn агентлагийн эрхлэгч Д.Эрдэнэцэцэг, ХМЗ-ийн төслийн менежер А.Амартүвшин нар болон Монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн “Цагаан үзэг холбоо”, Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ, Харилцаа холбооны зохицуулах хороонд талархал илэрхийлье!

ХМЗ-ийн гүйцэтгэх захирал

Г.Гүнжидмаа



**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН
ЗАРЧМЫН ДӨРӨВДҮГЭЭР ЗААЛТЫГ
ТАЙЛБАРЛАХ НЬ**

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧМЫН ДӨРӨВДҮГЭЭР ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ-ДӨРӨВДҮГЭЭР ЗААЛТ

4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.

4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.

4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.

4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.

4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.

4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.

4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.

Дэлхийн ихэнх улсын сэтгүүлчдийн дагаж мөрддөг Ёс зүйн зарчимд заавал байдаг нэг заалт бол гэмт хэрэг, осол, гамшигийг хэрхэн сурвалжилж мэдээлэх, гэмт хэрэг болон осол гамшигийн хохирогчид, тэдний ар гэрийнхэнтэй хэрхэн харьцах тухай юм.

Монголын Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчим үүнийг **“АЛИВАА МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИСГҮЙ ХЭЛБЭРЭЭР ДУУЛИАНТАЙГААР ТҮГЭЭХЭЭС ТАТГАЛЗАНА”** хэмээн ерөнхийлөн томъёолж, IV заалт болгон багтаасан. Энэхүү заалт нь дотроо 6 зүйл болон задарч, 6 өөр агуулга, хэмжүүрийг агуулдаг.

Гэмт хэргийн мэдээлэл бол хэзээ ямагт хамгийн их уншигддаг, үздэг мэдээний төрөл байсаар ирсэн. Яагаад гэвэл энэ төрлийн мэдээ хүний сониуч зан, бусдын талаарх мэдэх гэсэн байгалийн зөнг өдөөж байдаг. Ийм байсаар ирсэн, одоо ч ийм байсаар байгааг сэтгүүлчид, редакторууд дуу нэгтэй хүлээн зөвшөөрөх байх.

Сэтгүүл зүйн салбарынхан Пулицерын шагналын талаар сайн мэддэг. Энэ шагналын эзэн болно гэдэг салбартаа бусдаас илүү байж чадсан гэсэн үнэлэмжийг илэрхийлдэг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн, мөн шар хэвлэлийн үндсийг тавьсан гэж үздэг Пулицерын эрхлэн гаргадаг байсан сонинны зай талбайн чамгүй хэсгийг чухамхүү гэмт хэргийн мэдээлэл эзэлж байсан.

Гэмт хэргийн мэдээлэл гэдэг бол тухайн нийгмийн толь мэт тусгал нь. Тухайн нийгэмд ямар төрлийн гэмт хэрэг гарч байгаа талаарх мэдээллийг хүмүүст өгөхийн зэрэгцээ энэ мэдээллийг уншсан хүмүүст аливаа гэмт хэргээс өөрийгөө болоод эргэн тойрны хүмүүсээ хамгаалах далд ухамсарыг бий болгож өгдөг. Энэ бол эрүүл үзэгдэл гэж сэтгэл зүйчид үздэг. Гэвч нөгөө талаараа гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн талаар нарийвчлан бичих нь сэтгэцийн хувьд цоо эрүүл биш хүмүүст сэдэл болох, бас нийгэмд гадуурхагдсан, хүчирхийлэлд өртөж сэтгэл зүйн гэмтэл авсан хүмүүсийн хувьд өширхөх, хариугаа авах бодлыг төрүүлэх магадлалтайг анхааруулдаг.


Гэмт хэргийг илрүүлдэг детектив зохиолууд утга зохиолын түүхэнд хамгийн гүйлгээтэй номын байр сууриа алдаагүй л байна. Хүний таамаглах, ажиглах, мөшгөх, нөхцөл байдлыг логик дарааллаар холбох зэрэг шинж чанарыг детектив зохиол хөгжүүлдэг.

Харин гэмт хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх нь детектив зохиолоос илүүтэй олны анхаарлыг татдаг, яагаад гэвэл энэ нь хэн нэгэн зохиолчийн уран сэтгэмжээс бүтээгүй, харин таны хажууханд болж байгаа бодит үйл явдал учраас хүн өөрийн эрхгүй гэмт хэргийн талаарх мэдээлэлд анхаарал хандуулдаг.

Уншигчийн сонирхолд хөтлөгдөх үү, сэтгүүл зүйн зарчимд хөтлөгдөх үү?

Гэмт хэргийн мэдээлэл нь олны анхаарал татахын хэрээр сэтгүүлчээс, редактораас, редакцаас ур чадвар, хариуцлагатай байдал, хүнлэг ёсыг шаардана. Энэ төрлийн мэдээлэл нь нимгэн мөсөн дээр явж байгаа мэт мэдрэмж шаарддаг төрөл. Олж авсан мэдээлэл болгоноо хүргэх, бусдаас илүү байх, хурдан байх гэсэн хүсэл алдаанд хүргэх нь бий, ялангуяа гэмт хэрэг, осол гамшиг, аливаа хохирогчийн талаар мэдээлэх үед санамсаргүй алдаа гаргадаг. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн мэдээнд сэтгүүлч дотоод шаталтаа, бас илүү байх гэсэн амбицаа хязгаарлах хэрэгтэй болдог.

Гэмт хэргийн талаарх мэдээ бичихдээ дараах асуултад хариулаарай.



- 1 АСУУЛТ Энэ гэмт хэргийн талаар мэдээлэх нь олон нийтийн тусын тулд уу?
- 2 АСУУЛТ Энэ мэдээ бага насны хүүхдүүдэд хэрхэн нөлөөлөх вэ?
- 3 АСУУЛТ Энэ мэдээг уншаад хүн сургамж авах уу?
- 4 АСУУЛТ Энэ мэдээ нийгэмд айдас төрүүлэх үү?
- 5 АСУУЛТ Энэ мэдээ бусдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадах уу?

Эдгээр асуулт сэтгүүлч болон редакцид өөрийн цензур шиг санагдаж болох ч үр дагаврыг өөртөө болоод ойр дотнын хайртай хүмүүсийнхээ өмнөөс бодолцож үзээд, эдгээр асуултад хариулаад, бичсэн мэдээгээ дахин нэг засварлахад гэмгүй. Ялангуяа хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн мэдээнд “нүцгэн” баримт өгөөд орхих биш дахин ийм хүчирхийлэл гаргуулахгүй байх орчин нөхцөл нийгэмд бий болох ёстой гэсэн ухамсарыг уншиж байгаа хүмүүст бий болгох нэмэлт мэдээлэлтэй байх нь зүйтэй. Тухайлбал, сэтгэл зүйчийн зөвлөгөө, боловсролын байгууллагын төлөөллийн байр суурийг нэмэлт эх сурвалжаар оруулж болно.



Буруу юу? Зөв үү?

Хэн нэгний гэм буруутай эсэхийг сэтгүүлч шүүдэггүй

Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчмын IV дэх “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана” гэсэн заалт нь дотроо зургаан задаргаатай. Үүнээс сэтгүүлчдийн хамгийн их зөрчдөг заалт бол **4.2 буюу “Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй”** гэсэн хэсэг юм.

ХМЗ байгуулагдсан 2015 оноос хойш иргэдээс ёс зүйн гомдлуудыг хүлээн авч, өөрийн журмын дагуу шийдвэрлэж ирсэн. Өнгөрсөн хугацаанд 500 илүү гомдол ирсэний дотор 4.2 гэсэн заалт байнга дурдагдсаар ирсэн. 2023 болон 2022 онд ХМЗ-ийн Ёс зүйн хороогоор шийдэгдсэн гомдлуудаас харахад 4.2 дугаар заалтыг зөрчсөн тохиолдол 3 гарчээ. Сонирхолтой нь энэ 3 зөрчил нэг редакцад буюу peguun.mn сайтад хамаарч байна.

Жич: *Ёс зүйн хорооны шийдвэр хоёр янзаар гардаг. Ёс зүйн алдаа гаргасан редакцийн нэрийг дурдахгүй, эсвэл редакцийн нэрийг дурдан олон нийтэд мэдээлдэг журамтай. Энд жишээ авч буй редакцуудад хамаарах гомдлыг “нэрийг дурдан олон нийтэд мэдээлнэ” гэж шийдсэн учраас редакцын нэрийг нууцалсангүй. Хорооны шийдвэрийг ХМЗ-ийн цахим хуудаснаас хүссэн хүн нь үзэх боломжтой.*

ЖИШЭЭ 1.

Neuun.mn сайт 2023 оны нэгдүгээр сард эмч, эмнэлгийн хариуцлагагүй байдлаас болж хэд хэдэн хүн амь насаараа хохирсон, тухайн эмнэлэг хугацаа нь дууссан болон Монгол Улсын Эмийн бүртгэлд байхгүй эм, тариа хэрэглэж байсан зэрэг асуудлыг хөндөн цуврал мэдээ бэлтгэсэн бөгөөд эдгээр нь бүгд шууд дамжуулалт байжээ.

Эмнэлгийн зүгээс редакцыг мэдээллээ бүрэн нягтлалгүй, бодит байдлаас зөрүүтэйгээр мэдээлсэн, хүний амь нас, эрүүл мэндэд санаатайгаар заналхийлэл учруулж байна хэмээн олон давтан мэдээлсэн, энэ асуудал нь хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа учир мэдээлэл өгөх боломжгүй гэдгийг тайлбарлаад байхад ахин дахин тайлбар авна гэж дайрсан, ар гэрийнхэнд нь мэдэгдэлгүй цогцсыг нууж зөөвөрлөсөн хэмээн ор үндэсгүй мэдээлсэн нь сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг маш ноцтойгоор зөрчсөн, амь насаа алдсан шалтгаан бүрэн тодорхой болсон, үүнд эмнэлэг буруутай мэтээр баримтгүйгээр, зориудаар мушгин гуйвуулсан мэдээлэл цацсан, энэ нь хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байгууллага, ажилчдад болон шалгах үйл ажиллагаанд гаднаас зориуд санаатайгаар нөлөөлөх зорилго агуулсан хэмээн үзээд тус сайтын мэдээлэл нь Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1, 1.2, 1.3, 1.5, 1.6, 3.2, 4.2, 6.6 дахь заалтуудыг зөрчсөн эсэхэд дүгнэлт гаргуулахыг хүссэн.

Ёс зүйн хороо уг гомдлыг хэлэлцээд редакц хэдий зайлшгүй анхаарах ёстой чухал асуудлыг хөндсөн ч холбогдох эх сурвалжуудаас тухайн үйл явдлууд болсон эсэхийг тодруулж, баталгаажуулаагүй. 2016 болон 2022 онд нас барсан гэх хоёр хүний мэс заслын үеэр болсон үйлдэл бүрийг хажуугаас нь харж байсан мэтээр ингэсэн, тэгсэн хэмээн дүгнэн ярьж үзэл бодлоо оруулсан. Мэдээллүүд нь ямар нэг байдлаар нотлогдоогүй, тодорхой эх сурвалжгүй байхад таамаг гэдгийг дурдалгүй баталгаатай мэтээр мэдээлсэн, эмнэлгийг төлөөлөн яриа өгсөн эмч нь хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа асуудал учраас мэдээлэл өгөх боломжгүй, өмнөх болсон асуудлуудын үеэр ажиллаж байгаагүй учраас мэдэхгүй байна гэдгээ илэрхийлж буйг үл харгалзсан. Шууд дамжуулалтын үеэр дурдаж буй асуудлууд үнэхээр болж байсан уу, асуудал үүсч байсан уу гэдгийг эрх бүхий байгууллагуудаас тодруулалгүй удаа дараа шууд буруутгасан өнгө аясаар, “санаатайгаар хүний амь нас, эрүүл мэндийг хохироож байна” гэх зэргээр мэдээлсэн гэж үзсэн. Иймээс ёс зүйн зарчмын 1.1, 1.2, 1.3, 1.5, 1.6, 4.2 дахь заалтуудыг зөрчсөн гэж хороо үзэв.



ЖИШЭЭ 2.

Nequiin.mn сайт нь 2022 оны гуравдугаар улиралд “Сүнжин грандын нууц караоке” нэртэй шууд дамжуулалт “Сүнжин гранд” буудлаас дамжуулсан. Энэ үеэрээ уг объектод сэтгүүлч хууль бусаар дайран орсон, үйлчлүүлэгчдийг доромжилсон, жуулчдыг биеэ үнэлэгч авсан мэтээр байцаасан, нүүр царайг нь олон нийтэд ил тод харуулсан, хөтөч хийж байсан эмэгтэйчүүдийг биеэ үнэлэгч мэтээр гүтгэн доромжилсон, насанд хүрээгүй охидын биеийг хүчээр үнэлүүлдэг хэмээн өөрсдийн сэтгэл хөдлөлөөр бизнесийн нэр хүндэд ноцтой халдаж гүтгэсэн хэмээн “Сүнжин гранд” зочид буудлыг эзэмшигч “Сонжин групп” ХХК-иас ХМЗ-д гомдол ирүүлсэн. Гомдолдоо Ёс зүйн зүйн зарчмын хэд хэдэн заалтыг nequiin.mn сайт зөрчсөн гэж үзсэний дотор 4.2 заалт байсан.

Шууд дамжуулалтад биеэ үнэлсэн нь баталгаатай нотлогдсон мэтээр мэдээлсэн, караокед байсан эмэгтэйг биеэ үнэлэх гэмт хэрэгт буруутган шууд тулгасан асуултууд тавьсан гэж үзэн редакц 4.2 заалтыг зөрчсөн хэмээн үзжээ.



ЖИШЭЭ 3.

Nequiin.mn сайт нь 2022 оны гуравдугаар улиралд “Сүнжин грандын нууц караоке” нэртэй шууд дамжуулалт “Сүнжин гранд” буудлаас дамжуулсан. Энэ үеэрээ уг объектод сэтгүүлч хууль бусаар дайран орсон, үйлчлүүлэгчдийг доромжилсон, жуулчдыг биеэ үнэлэгч авсан мэтээр байцаасан, нүүр царайг нь олон нийтэд ил тод харуулсан, хөтөч хийж байсан эмэгтэйчүүдийг биеэ үнэлэгч мэтээр гүтгэн доромжилсон, насанд хүрээгүй охидын биеийг хүчээр үнэлүүлдэг хэмээн өөрсдийн сэтгэл хөдлөлөөр бизнесийн нэр хүндэд ноцтой халдаж гүтгэсэн хэмээн “Сүнжин гранд” зочид буудлыг эзэмшигч “Сонжин групп” ХХК-иас ХМЗ-д гомдол ирүүлсэн. Гомдолдоо Ёс зүйн зүйн зарчмын хэд хэдэн заалтыг nequiin.mn сайт зөрчсөн гэж үзсэний дотор 4.2 заалт байсан.

Шууд дамжуулалтад биеэ үнэлсэн нь баталгаатай нотлогдсон мэтээр мэдээлсэн, караокед байсан эмэгтэйг биеэ үнэлэх гэмт хэрэгт буруутган шууд тулгасан асуултууд тавьсан гэж үзэн редакц 4.2 заалтыг зөрчсөн хэмээн үзжээ.

4.2 бол маш тодорхой заалт

Уг нь 4.2 заалт бол маш ойлгомжтой, тодорхой заалт. Сэтгүүлч, редакцад буруутгаж байгаа хүнээ гэм буруутайг нотлох хангалттай баримт байлаа ч шүүгчийн алх цохихоос өмнө гэм буруутай гэж мэдээлэх нь алдаанд тооцогдоно. Энэ бол буруутгагдаж байгаа хүний нэр хүндийн асуудал. Цаашлаад хүний эрхийн мэдрэмжийн асуудал юм. Гэм буруутайд буруутгалгүй, олсон баттай мэдээллээ баримттай нь хамт дэлгээд орхиход хангалттай.

2023 оны наймдугаар сард Их Британид нярай хүүхдүүдийн амийг хөнөөсөн сувилагчид бүх насаар нь хорих ялыг шүүхээс оноосон. Уг хэрэг 2015-2016 онд үйлдэгдсэн бөгөөд гэмт хэрэгтнийг 2021 онд баривчлан хоёр жил шахам мөрдөн шалгасны эцэст энэ оны наймдугаар сард шүүхээс ял оноосон. Энэ хэргийн талаар Их Британийн хэвлэлүүд мэдэж байсан ч шүүх хэргийг шүүн хэлэлцэж эхэлснээс хойш ял оноох хүртэл зөвхөн процессийг албан ёсоор сурвалжлан мэдээлснээс биш сувилагч Люси Летби “харгис алуурчин”, “гэм буруутай” гэсэн үгсийг шүүхийн тогтоол гарах хүртэл мэдээ, сурвалжлагандаа хэрэглээгүй юм.

Гэмт хэрэг, осол, гамшгийг сурвалжлахад ур чадвараас гадна туршлага хэрэгтэй

Гэмт хэрэг, осол гамшгийн мэдээ нь сэтгүүлчээс ур чадвараас гадна хүнлэг байдал, хариуцлагатай байдал, мөн туршлагатай байхыг шаарддаг. Сэтгүүлчийн карьераа эхэлж байгаа 20 гаруй насны сэтгүүлчийг хүн амины хэрэг, уй гашуутай осол гамшгийн сурвалжлагад томилохгүй байх нь хэн хэндээ зөв шийдэл болно.

Туршлагатай редактор мэдээж ийм шийдвэр гаргахгүй. Ийм хэргийн газарт сурвалжлага хийж байгаа сэтгүүлч хэргийн хохирогч, эсвэл хохирогчийн ар гэрийнхэнтэй уулзаж мэдээлэл олохыг чармайх нь ойлгомжтой. Цочирдсон хохирогч болон ар гэрийнхний зүрх сэтгэлийг мэдэрч, зөв асуулт тавьж, эвийг олж ярилцахад туршлага хэрэгтэй. Цочролд орсон хохирогч болон ар гэрийнхэн нь хувийн нууц мэдээллээ дэлгэх, эсвэл сандарч балмагдсандаа өөрөө мэдэлгүйгээр буруу мэдээлэл өгч болно. Ийм үед олсон мэдээллийг дэлгэх нь зөв үү, уг мэдээлэл нийтэд цацагдсанаар хохирогчдод яаж тусах талаар дахин дахин тунгаан бодох шаардлагатай. Учир нь, энэ бол баттай эх сурвалжаас авсан мэдээлэл мөн боловч хохирогчийн эрх, сэтгүүлчийн ёс зүй гэсэн шүүлтүүрээр орж байж мэдээлэгдэх учиртай.

Хохирогч, бас гэтлэгч

Дөрөвдүгээр заалтад хохирогч гэж дурдсан нь агуулгын хувьд учир дутагдалтай. Хохирогч гэдэг бол илүүтэй гэмт хэргийн улмаас бие организм, эд хөрөнгө, сэтгэл санааны хувьд хохирсон гэсэн ойлголт. Харин гэнэтийн осол, гамшгийн үед хохирогч гэдэг үгээс илүүтэй гэтлэгч (англиар survivor) гэх нь илүүтэй агуулгадаа ононо. Гэтлэгч гэсэн үг нь гэмт хэрэгт ч бас хамаатай. Тиймээс гэтлэгч /эсвэл даван туулагч/ гэсэн агуулгыг Ёс зүйн зарчмын дөрөвдүгээр заалтад оруулах нь зүйтэй.

Мэргэжлийн сэтгүүлч, мэргэжлийн редакц

Гэмт хэргийн мэдээлэл нь улс төр, соёл, нийгмийн зэрэг бусад мэдээллийн нэгэн адил бодитой, хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүйн зарчим, ур чадварт суурилах учиртай. Бүх мэдээлэл чинь нягт нямбай шалгагдсан, тоо баримт зөв, эх сурвалжтай байх учиртай.

Гэмт хэрэг, осол гамшгийн мэдээлэл хохирогчийн мэдээлэлгүйгээр амьгүй. Гэхдээ энэ нь мэдээгээ амь оруулахын тулд цочирдож, балмагдсан, хохирогчийг эрээ цээргүй байцаах эрхийг олгохгүй.

Бас нөгөө талаар хохирогч танд уураа гаргаж мэдэх учраас болгоомжлоход илүүдэхгүй. Сэтгэл зүйн хувьд уурссан байж болно.

Бас нэг анхаарах зүйл бол гэмт хэргийн тухай мэдээлэл бэлтгэж байх үед цагдаа, прокурорын байгууллагынханд ашиглуулах магадлалтай. Тэдний зүгээс зөвхөн өөрт ашигтай мэдээллийг өгч, бодит байдлыг илтгэх бусад мэдээллийг нуух магадлалтай.

Цагдаагийн байгууллага таниас мэдээллээ цацахаа түр азнаач гэж гуйж болно. Мэдээлэл цацагдсанаар өөр бусад хүмүүсийн амь нас хохирох эрсдэлтэй байх магадлалтай үед хамтран ажиллах нь зүйтэй. Гэхдээ энэ шийдвэрийг редактор, редакциягаа ярилцаж байж шийдэх нь зүйтэй.

Дөрөвдүгээр заалтын хамгийн олон зүйл зөрчигдсөн гомдлын талаар

2021 оны эхээр Сонин, сайт сэтгүүлийн Ёс зүйн хороогоор хэлэлцэгдсэн нэг гомдол нь 4-р заалтын хамгийн олон зүйл зөрчсөн гэж дүгнэсэн байдаг.

Энэ гомдол eduug.mn сайтад 2021 оны хоёрдугаар сарын 8-ны өдөр нийтлэгдсэн “ХЭРГИЙН ГАЗАР: Нэгнээ цахилгаан шатанд хутгалж, өөрөө дээврээс үсэрч амиа алджээ” гэсэн гарчигтай сурвалжлагад хамаатай. Энэ хэрэг Улаанбаатар хотын нэгэн дүүрэгт гарсан бөгөөд амиа алдсан хоёр талийгаач олны танил, ялангуяа залуусын дунд танигдсан хүмүүс байсан.

ХМЗ-д ирүүлсэн гомдолдоо иргэн, Б.Х “Хэрэгт нэр холбогдсон талийгаачдын болон хэрэгт хамааралтай байж болох хүмүүсийн хувийн мэдээллийг нээлттэй цацсан, хэрэг болсон хаяг байршил, хэргийн ул мөрийг харуулсан гэрэл зургийг нийтэлж, болсон явдлыг дэлгэрэнгүйгээр бичсэн нь мэргэжлийн ёс зүйн олон зарчмыг зөрчсөн” гэж үзсэн байсан.

“ХМЗ-ийн Гомдол хүлээн авах, барагдуулах журамд заасны дагуу гомдол хаяглагдсан редакцаас тайлбар хүсч байр суурийг нь харгалзан үздэг. Энэ дагуу eduug.mn сайтын редакц тайлбар ирүүлсэн. Редакц ирүүлсэн тайлбартаа энэхүү хэргийг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлсэнийг дурдаад хэрэгт холбогдсон болон хамааралтай хүмүүсийн хувийн мэдээллүүдийг ил гаргаагүй, бусад хэвлэл мэдээллийн байгууллагын адил хэвлэн нийтлэх, мэдээлэх үүргээ биелүүлж, хэрэг явдлыг бодитоор, баримттайгаар хүргэхийг зорьсон, тус мэдээлэлд худал, үнэнээс зөрүүтэй ноцтой мэдээлэл байхгүй боловч тухайн байрны хэдэн давхраас унаж амиа алдсан талаар хэт деталь байж болох хэсэг орсон байна гээд “цаашид энэ байдалдаа анхаарч сэтгүүлчийг ийм нөхцөл байдалд ямар үг сонгох, явал хүний эрх зөрчихгүй байх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөж, зааж сургах болно” гэдгээ илэрхийлжээ.

Сурвалжлагад хэргийн газрыг маш нарийн харуулсан гэрэл зураг, үг хэллэг ашигласан тул 4.1-т заасан “Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ” гэснийг, мөн тухайн хэрэг гарсан байр, давхар, хаалга, цахилгаан шат, цусны толбо болсон хувцас зэргийн гэрэл зургийг ямар нэг шүүлтүүргүйгээр харуулсан тул 4.4-т заасан “Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана” гэснийг, хэргийн газрын гэрэл зургийг маш нарийн, тодорхой, ямар нэг шүүлтүүргүйгээр харуулсан тул 4.6-д заасан “Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр

дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана” гэснийг тус тус зөрчсөн гэж Ёс зүйн дүгнэлтээ гаргасан.

Хохирогчийн эрхтэй холбоотой өөр нэг жишээ

Энэ гомдолтой холбоотой хэрэг нийгмийг цочроосон хэрэг байсан. КОВИД-19-ийн цар тахлын хэсэгчилсэн хөл хориотой байх үед буюу 2021 оны хоёрдугаар сарын 8-ны өдөр нэгэн иргэн нийслэлийн төв Сүхбаатарын талбайд өөрийгөө галдаж, амь насаа алдсан харамсалтай хэрэг гарсан. Энэ золгүй хэргийн талаар бүхий л хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээлсэн ч ХМЗ-д иргэн Н.А цахим мэдээллийн гурван сайтад холбогдуулан гомдол ирүүлсэн.

Эдгээр сайт нь уг золгүй хэргийн талаар мэдээлэхдээ өөрийгөө галдсан иргэний гэрэл зургийг танигдахаар нийтэлсэн, нэгэн иргэний хувиараа хийж сошиал сүлжээгээр цацсан хэргийн талаарх дүрс бичлэгийг ямар нэг шүүлтүүргүйгээр бүрэн харуулсан нь 4.4, 4.5, 4.6-р зүйлийг зөрчсөн, эдгээр сайтын мэдээлэл нь талийгаачийн ойр дотны хүмүүс, мөн хүүхэд, өндөр настангуудад эмзэг тусахаар байна хэмээн гомдолдоо дурдсан.

Гомдолд нэр дурдагдсан гурван редакцын тайлбарыг үндэслэн Ёс зүйн хороо дараах шийдвэрийг гаргасан юм. Тухайлбал, нэг редакц нь ёс зүйн ямар нэг зөрчил гаргаагүй, хоёр дахь нь зөрчил гаргасан ч редакц алдаагаа ойлгож, тэр даруй залруулга хийж, уншигчдаасаа уучлал хүссэн тул редакцын нэрийг олон нийтэд зарлахгүй, харин 3 дахь буюу ergelt.mn сайтыг ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэн нэрийг нь олон нийтэд нээлттэй мэдээлэх дүгнэлтийг гаргасан билээ.

Зөрчил гаргаагүй гэж үзсэн редакц хариу тайлбартаа “дээрх мэдээллийг бэлтгэхдээ ёс зүйн алдаа гаргаагүй” гэж үзэж байгаагаа илэрхийлээд гомдол гаргагчийн дурдсан заалт тус бүрт тайлбар ирүүлсэн байсан. “Тухайн хэрэг явдлын зургуудаас зөвхөн ийм хэрэг гарсан гэдгийг нотлох зураг сонгон нийтлэхдээ хэт ойроос аваагүй, хүний сэтгэл зүйд шууд сөргөөр нөлөөлөхөөргүй зураг сонгосон, болсон хэрэг явдлын талаар цагдаагийн байгууллагын эрх бүхий хүнээс тайлбар авч оруулсан бөгөөд гэмт хэрэг, осол гамшгийн мэдээллийг иргэдэд сэрэмжлүүлэх үүднээс бэлтгэдэг зарчмын хүрээнд мэдээлсэн, тухайн хэргийн процессыг харуулсан видео, гэрэл зураг байсан ч редакцын шийдвэрээр тэдгээрийг ашиглах нь ёс зүйгүй гэж үзээд ашиглаагүй” гэдгээ тайлбартаа дурдсан байсан.

Хоёр дахь редакцын тайлбарт “Тухайн хэрэг гарах үед манай сэтгүүлч, зураглаач хоёр шууд дамжуулахдаа талийгаачийн царайг татаж харуулсан нь алдаа болсон. Бид алдаагаа тэр даруйд харж шууд дамжуулалтаа дуусангуут тухайн хүний царай тод гарсан хэсгийг бүрсийлгэн зассан. Түүнчлэн манай сайтын ерөнхий эрхлэгч өөрийн социал хуудсаараа дамжуулан уучлалт гуйсан” болохыг дурдсан. Гэсэн ч шууд дамжуулалтын үеэр цогцсыг татаж харуулснаар өмссөн хувцас нь тодорхой харагдаж байсан. Ингэснээр гэр бүл, ойр дотныхон нь таних, цочролд орох эрсдэлтэй байсан тул 4.6-д заасан “Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана” гэснийг зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан.

Ergelt.mn сайт ХМЗ-д редакцын тайлбар ирүүлээгүй юм. Тус сайтад нийтлэгдсэн сурвалжлага “ШУУРХАЙ: 34 настай Э.Энхтөгс гэх залуу Сүхбаатарын талбай дээр өөрийгөө шатааж, амиа алдлаа” гэсэн гарчигтай, сурвалжлагад талийгаачийн хэт ойроос авсан гэрэл зургийг нийтэлсэн нь хүний сэтгэл сэртхийлгэм, маш өрөвдөлтэй харагдуулсан, ар гэрийнхэн нь үзээд ямар байх тухай огтхон ч бодоогүй, амиа хорлосон иргэний овог нэр, нас, хаана ажиллаж байсан зэрэг хувийн мэдээллийг түүнийг таньж мэддэг хүмүүст шууд хэн гэдэг нь ойлгогдохоор ил болгосон, Сүхбаатарын талбайн баруун талаас алхаж орж ирэхдээ өөр дээрээ таван литрийн цэвэр усны саванд хийсэн шатахуун асгажээ. Ингээд 20 орчим алхаад шүдэнз зурж өөрийгөө шатаасан хэмээн амиа хорлох аргыг нарийвчлан бичсэн нь бусад хүмүүс санаа сэдэл авахаар байсан зэрэг нь Ёс зүйн зарчмуудыг зөрчсөн гэж үзсэн юм.





**ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ
СУРВАЛЖЛАХ ЗӨВЛӨМЖ**

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ СУРВАЛЖЛАХ ЗӨВЛӨМЖ

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь ихэнхдээ далд, нууц хэлбэрээр оршин тогтнож байдаг. Нийгэмд түгээмэл ажиглагддаг хохирогчийг буруутгах хандлагаас болж энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн, хохирсон хүмүүс хуулийн байгууллагад хандахгүй байх, эрүүл мэндийн болон сэтгэл заслын зохих үйлчилгээ авч чадахгүй үлдэх нь элбэг. Мөн айдас, түгшүүр, бусдын зүгээс үзүүлэх дарамт, заналхийлэл зэрэг олон шалтгааны улмаас даван туулагчид ил гарах, хэвлэл мэдээллийнхэнд хандахаас зайлсхийдэг.


Гэтэл жендэрт суурилсан хүчирхийлэл нь нийгмийн хувьд тулгамдсан асар том асуудал болчихоод байгааг мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаа харуулж байна. Тийм ч учраас хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид эдгээр асуудлыг ул суурьтай судалж, зөв өнцгөөс хөндөж олон нийтэд хүргэх нь чухал. Сүүлийн жилүүдэд энэ тал дээр нэлээд ахиц дэвшил гарч байгааг тэмдэглүүштэй.

Гэвч жендэрт суурилсан хүчирхийлэл нь далд, нууц хэлбэрт байдгаас гадна маш эмзэг сэдэв учраас мэргэжлийн, туршлагатай сэтгүүлч хүртэл алдаа гаргах, улмаар даван туулагч, түүний үр хүүхдүүдийн амьдрал, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах тохиолдол бий.

Мөн “Cory-cat effect” буюу сэдэл төрүүлэх нөлөө үзүүлэх эрсдэл ч энэ сэдвийг байнга дагалдаж байдаг. Хүчирхийлэл, амиа хорлолтын аймшигт хэргүүдийг дуулиан шуугиан болгон мэдээлснээр тийм арга замаар үйлдсэн хэргийн тоо өсч байгааг баримтжуулсан судалгаанууд ч байна.

Иймд жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөх нь сэтгүүлчээс ёс зүйн сахилга бат, мэдрэмж, судалгаа хийх мэргэжлийн ур чадвар, ярилцлага хийх тусгай арга барил болон энэ төрлийн гэмт хэрэг, хууль эрх зүйн орчны талаарх мэдлэг, боловсрол зэргийг цогцоор нь шаарддаг. Энэ бүхнийг цогцлоон бүрдүүлэхэд туслах зөвлөмжийг дараах боловсрууллаа.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх хэвшсэн буруу ойлголт, хандлага



ХУДАЛ	ҮНЭН
Эмэгтэй хүн “үгүй” гэвэл “тийм” гэсэн үг.	“Үгүй” гэвэл “үгүй” л гэсэн үг!
Бэлгийн хүчирхийллийг үргэлж танихгүй хүн үйлддэг бөгөөд харанхуй шөнө гадуур ганцаараа явахад тохиолддог.	Судалгаанаас үзэхэд дөрвөн хохирогч тутмын гурвыг ямар нэг байдлаар таньж мэддэг хүн нь хүчиндсэн байна (ХТЭТ, 2018).
Найз залуу, эсвэл нөхөртөө хүчиндүүлнэ гэсэн ойлголт байхгүй. Өмнө нь дотно харилцаатай байсан бол тэр хүчингийн хэрэг биш.	Хүч хэрэглэн, айлган сүрдүүлж бэлгийн харьцаанд оруулах нь хүчингийн хэрэг мөн. Үүнд гэр бүл болсон, эсвэл өмнө нь бэлгийн харьцаанд орж байсан эсэх хамаагүй.
Бэлгийн хүчирхийлэлд зөвхөн эмэгтэйчүүд өртдөг.	Бэлгийн хүчирхийлэлд хэн ч өртөж болно. Эрэгтэйчүүд, ЛГБТИК хүмүүс ч хохирогч болдог.

<p>Хэт ил задгай хувцас өмссөнөөсөө болж л бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог.</p>	<p>Юу өмсч, яаж харагдах нь хүчирхийлэлд өртөхөд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Манцуйтай хүүхдээс эхлээд тэргэнцэртэй настай хүн хүртэл бэлгийн хүчирхийлэлд өртөх тохиолдол гардаг. Хүчин гэдэг бол зөвхөн хүчирхийлэгчийн буруу!</p>
<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч нь өөрөө тийм байдлыг бий болгодог. Хэрвээ хүсвэл нөхөр, найз залуугаасаа салж болох л байсан.</p>	<p>Хохирогч хүчирхийлэгчээс хамааралтай байх тохиолдол элбэг бөгөөд ичиж зовох, өөрийгөө буруутгах, бие даан амьдрах чадваргүй байх, дарамт, сүрдүүлгээс айх зэрэг олон шалтгааны улмаас харилцаагаа тасалж чадахгүй байдаг.</p>
<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлд зөвхөн ядуу, ажилгүй эмэгтэй өртдөг.</p>	<p>Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн хувьд нас, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, байршлын онцлог ялгаа ажиглагдахгүй байгааг судалгаа харуулсан</p>
<p>Эрэгтэйчүүд бэлгийн дур хүслээ дарж чадахгүй болохоор л хүчирхийлэл үйлддэг.</p>	<p>Хүчирхийлэгч өөрийн эрх мэдэл хүчний давуу байдлаа ашиглан хэн нэгнийг хүсэл зоригийнх нь эсрэг хүчирхийлдэг.</p>
<p>Хүчирхийлэл үйлдэгчид сэтгэцийн өвчтэй, аймшигт араатнууд байдаг.</p>	<p>Ямар ч хүн хүчирхийлэгч байж болно. Гэр бүлийн гишүүнээс эхлээд олны танил, нэр хүндтэй хүн ч хүчирхийлэл үйлддэг.</p>

Хохирогчийг буруутгах хандлага гэж юу вэ?

Аливаа осол, гэмт хэргийн хохирогчийг болсон явдалд бүрэн, эсвэл тодорхой хэмжээгээр буруутгахыг хохирогчийг буруутгах хандлага гэдэг (The Canadian Resource Centre for Victims of Crime, 2009). Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүнийг амьдралын хэв маяг, хувцаслалт, биеэ авч явах байдал, үйлдэл зэргээр нь буруутгах хандлага нийгэмд түгээмэл. Гэтэл амьдралын хэв маяг ямар байхаас үл шалтгаалан хүчирхийлэлд хэн ч өртөж болно.

Сэтгүүлч хүн жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлын талаар бичихдээ хохирогчийг буруутгах сэдэл төрүүлэхүйц мэдээлэл өгөхгүй байх нь чухал. Учир нь, хохирогчийг буруутгах хандлагаас болж дараах сөрөг үр дагаврууд бий болдог. Үүнд,

- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгчид ихэнхдээ бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртсөн байдаг. Мөн нийгэмд хохирогчийг буруутгах хандлага түгээмэл байдаг учраас хохирогч ч өөрийгөө буруутгаж, сэтгэл санааны гүн хямралд орох нь элбэг.
- Сэтгүүлч хохирогчийг буруутгах алдаа гаргаснаар олон нийтэд хохирогчийг буруугаар ойлгуулах, буруутгах сэдэл төрүүлдэг. Ингэснээр хүмүүс гэмт хэрэгтнийг биш, хохирогчийг буруутгаад өнгөрнө. Энэ нь хүчирхийлэгчийн үйлдлийг өөгшүүлж, дахин давтан үйлдэх сэдлийг төрүүлдэг төдийгүй хүчирхийллийг зөвтгөх буруу хандлагыг нийгэмд бий болгодог.
- Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвүүд, хамгаалах байрууд, сэтгэл зүйчид болон мэргэжлийн хүмүүс бий. Хохирогчийг буруутгах хандлагаас болж хүчирхийлэлд өртөгч сэтгэл санааны нэмэлт дарамтад ороход тэдний ажлын үр дүн буурдаг.
- Хохирогч өөрийгөө буруутайд тооцвол, эсвэл хүмүүс түүнийг буруутгахаас айвал хүчирхийллийн тухай мэдээлэх магадлал буурна. Олон хүн ийм шалтгаанаас болж дуугүй өнгөрч, гэмт хэрэгтэн сул чөлөөтэй үлддэг. Энэ нь хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох ажлын хамгийн том саад бэрхшээл юм.
- Хохирогч хүчирхийллийн талаар мэдээлэхээс татгалзсан тохиолдолд зохих үйлчилгээг авч чадахгүй үлдэх магадлал өндөр. Ингэснээр насан туршийн сэтгэлийн шархтай үлдэнэ, мөн хүчирхийлэл даамжирч, давтагдсаар байх магадлалтай.

Иймд жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвийг хөндөхдөө сэтгүүлч хүн ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр баримталж, хохирогчийг буруутгах хандлагаас зайлсхийх шаардлагатай.

Ёс зүйн хэм хэмжээ ба даван туулагч төвтэй арга зүй

Даван туулагчийн эрх болон хэрэгцээ шаардлагыг хүндэтгэж, аюулгүй байдлыг хангаж, түүний эрхэм чанарыг дээдэлж харьцах таатай орчин бүрдүүлэхийг даван туулагч төвтэй арга зүй гэдэг (UNFPA, 2019). Даван туулагч төвтэй арга зүй нь дараах үндсэн зарчимд тулгуурладаг байна:

Аюулгүй байдал

Даван туулагч болон түүний хүүхдүүдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавина. Ёс зүйтэй сэтгүүлч эх сурвалжуудтайгаа үргэлж зүй зохистой, шударга харьцаж, эмзэг байж болох эх сурвалжийг хамгаалах хариуцлага хүлээдэг.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нээлттэй ярьж, мэдээлж буй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох хүмүүс олон бий. Мөн даван туулагчдыг хүчирхийлсэн хүмүүсийнх нь зүгээс айлган сүрдүүлэх, дарамтлах, хүчирхийлэх тохиолдол элбэг гардаг. Тийм ч учраас эх сурвалжийнхаа бие махбод болон сэтгэл санааны аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, няхуур нямбай ажиллах нь хамгийн чухал. Үүнийг тантай хамт ажиллаж буй зураглаач, хэлмэрч, жолооч гээд багийн бүх хүнд сайтар ойлгуулах хэрэгтэй. Түүнчлэн хүчирхийллийн талаар мэдээлэхдээ гэмт хэргийн үйлдлийг нэгбүрчлэн мэдээлэх нь энэ төрлийн гэмт хэргийн сэдлийг бий болгож, үйлдэгдэх магадлалыг өндөр болгодог аюултайг санаж байх нь зүйтэй.

Нууцлал

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын Зургаадугаарт “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана” гэж заасан. Хэнд өөрийн түүхийг ярих, эс ярихаа даван туулагч шийдэх эрхтэйг санаарай. Энэ хүрээнд эх сурвалжаасаа зөвшөөрөл авсны үндсэн дээр өгсөн мэдээллийг нь ашиглах, эш татах нь чухал.

Мөн хүчирхийллийн хохирогч болон гэр бүлийнх нь нууцыг хадгалах, хамгаалах нь мэргэшсэн, ёс зүйтэй сэтгүүлчийн үүрэг. Монгол Улс хүн ам цөөтэй учраас мэдээллийн нууцлал, хувь хүний халдашгүй байх эрхийг хангахад бэрхшээл тулгардгийг ойлгож, илүү няхуур ажиллах шаардлага

бий. Тухайлбал, хэдийгээр даван туулагчийн нэр, нүүр царайг нууцалсан ч оршин суугаа байршил, нас, ажил мэргэжил, хувцаслалт, гэр бүлийн гишүүдийнх нь талаарх мэдээлэл зэргийг өгснөөр хүмүүс түүнийг таних боломжтой.

Хүндэтгэл

Даван туулагчийн эрх, эрхэм чанарыг дээдэлж, түүний сонголт болон хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх хэрэгтэй. Сэтгүүлчийн хувьд энэ нь эх сурвалжийнхаа хувийн нууц, хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэхийг хэлнэ. Даван туулагчийн түүхийг эрхэм чанарыг дээдлэх байдлаар хүргэхээр чармайн ажиллах бөгөөд хохирогчийг буруутгах хандлага гаргахаас дээд зэргээр сэргийлнэ. Сурвалжлагч даван туулагчийг бүрэн гүйцэд ойлгож, түүний түүхийг мэдрэмжтэй, хариуцлагатайгаар олон нийтэд хүргэснээр эргээд уншигч, үзэгчдийн ойлгох сэтгэлийг өдөөх ёстой.

Ялгаварлан гадуурхал

Ялгаварлан гадуурхах, буруу зөвийг шүүх, шүүмжлэх нь хариуцлагатай сэтгүүлчийн хийх зүйл биш. Хүчирхийллийн талаар хэт дэлгэрэнгүй, нэгбүрчлэн мэдээлэх нь хохирогчийг буруутгах хандлагыг бий болгох эрсдэлтэй. Тухайлбал, хохирогчийн гадаад төрх, биеэ авч явах байдал болон гэмт хэрэг гарах үед өмсч байсан хувцас зэргийг дурдах онц шаардлагагүй. Зарим сэтгүүлч бүтээлээ илүү “амьд”, нүдэнд харагдахуйц болгохын тулд иймэрхүү мэдээллийг дурдсанаас болж хохирогчийг шүүмжлэх далд санааг илэрхийлж, улмаар олон нийтэд түүнийг буруутгах сэдэл төрүүлэх нь бий.

Жендэрт суурилсан хүчирхийллийг сурвалжлахдаа баримтлах зөвлөмж

БУРУУ	ЗӨВ
<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой сэтгүүл зүйн бүтээлийн дийлэнх буюу 60 орчим хувь нь цаг үеийн мэдээ байна (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Ийм хэргийг цаг хугацаанд баригдан, дуулиан шуугиан дэгдээх зорилгоор цөөн эх сурвалжид тулгуурлан өнгөц мэдээлээд өнгөрөх нь буруу.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар учир шалтгааныг задлан шинжилсэн бүтээл гаргахад хангалттай цаг хугацаа, мэргэжлийн нөөц бололцоо зарцуулах хэрэгтэй. Шаардлагатай бүх эх сурвалжаас мэдээлэл авч, экспертүүдээс зөвлөгөө авч, хангалттай контекст мэдээлэл болон тоо баримт, нотолгоонд суурилсан даацтай мэдээ, бүтээл хийхэд анхаарч ажиллаарай.</p>
<p>Хүчирхийлэл үйлдэгч өөрийгөө буруугүй гэж харагдуулах зорилгоор мэдээлэл өгөх нь элбэг байдаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэгч, хуулийн байгууллагын өгсөн мэдээлэл дээр үндэслэн нэг талыг барьсан агуулга бэлтгэж болохгүй.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүний дуу хоолой болон даван туулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтний байр суурийг заавал оруулж байгаарай. Хэрвээ даван туулагчтай ярилцлага хийх боломжгүй бол мэдээллийг тэнцвэртэй байлгахын тулд хүчирхийллийн эсрэг ажилладаг мэргэжилтнүүд болон хуулийн байгууллагуудын мэдээлэлд тулгуурлан агуулгаа бэлтгээрэй.</p>
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг дуулиан шуугиан дэгдээх зорилгоор хөндөж болохгүй. Энэ нь сэтгүүлч бүтээлээ буруу өнцгөөс барьж авах гол шалтгаан болдог. Тухайлбал, бэлгийн дарамт, хүчирхийллийн талаарх гомдол нь олны танил, эсвэл эрх мэдэлтэй хүний нэр төрд халдах гэсэн оролдлого гэсэн өнцгөөс харж огт болохгүй.</p>	<p>Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчмын Дөрөвдүгээрт “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана” гэж заасан байдаг.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийллийг гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил гэдэг талаас нь хөндөх шаардлагатай. Хангалттай контекст мэдээлэл, нотолгоонд суурилан яагаад ийм хэрэг гарахад хүргэснийг зөв өнцгөөс нь судалж гаргаарай.</p>

<p>Даван туулагчийг амьдралын хэв маягт нь тулгуурлан “муу”, “сайн” гэж, хийсэн үйлдэл, сонголтуудыг нь “буруу”, “зөв” гэж шүүх, дүгнэх хандлага ажиглагддаг.</p>	<p>Хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэдгийг маш сайн ойлгож, жөндөрт суурилсан хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил гэдэг өнцгөөс харах хэрэгтэй.</p>
<p>Жөндөрт суурилсан хүчирхийллийн тохиолдол, хохирогчийн талаар хэт дэлгэрэнгүй бичих алдаа элбэг гардаг. Сэтгүүлч заримдаа болсон явдлыг уншигч, үзэгчдийнхээ нүдэнд харагдтал дүрслэхийн тулд гэмт хэрэг болох үед хохирогч юу өмсч байсан, юу хийж байсан зэргийг дурддаг. Ингэснээр нийгэмд түгээмэл байдаг хохирогчийг буруутгах хандлагыг өдөөх, гэмт хэргийн сэдэл төрүүлэх аюултай.</p>	<p>Ярилцлага, сурвалжлагынхаа явцад олж авсан бүх мэдээллээ бүтээлдээ багтаах гэж битгий яараарай. Тухайлбал, даван туулагчийн өмсч байсан хувцас, эрхэлдэг ажил, гэр бүлийн байдал, одоогийн болон өмнөх харилцаа, биеэ авч явах байдал зэргийг нэн шаардлагагүй тохиолдолд дурдаж болохгүй.</p>
<p>Хүчирхийлэгчийг “урьдынхаасаа их өөр болсон”, “сэтгэцийн өвчтэй” гэдэг талаас нь дүрсэлж, үйлдлийг нь зөвтгөн тайлбарлах хандлага зарим бүтээлд ажиглагддаг (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Хэрэгт шууд холбогдолгүй баримт, мэдээллүүдийг оруулснаар ийм алдаа гарах нь бий. Жишээ нь:</p> <ol style="list-style-type: none">1. Хоёр хүүхдийн эцэг Х.Х.-г маш сайн аав, халамжит хань болохыг эхнэр нь хэлэв (бусдыг хүчирхийлсэн хэргийн талаар хөндөж байхад түүний эхнэр, хүүхдэдээ ямар сайн ханддаг байсныг бичих шаардлагагүй).2. Амжилттай, залуу улстөрчийн талаар нутгийн хүмүүс нь ам сайтай байдаг.	<p>Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчмын 4.3-т “Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй” гэж заасан.</p> <p>Жөндөрт суурилсан хүчирхийлэл үйлдэгчийн хувьд түүнийг ямар нэгэн байдлаар зөвтгөх, хийсэн хэргийг нь зөөлрүүлэх хандлага гаргахгүй байх нь чухал. Ялангуяа эрх мэдэл бүхий, эсвэл олны танил хүний үйлдсэн хүчирхийллийн талаар хөндөж байгаа бол түүнийг зөвтгөх, гэм буруугүй мэт харагдуулж болох мэдээллүүдийг оруулаагүй гэдэгтээ бат итгэлтэй байхын тулд дахин нягталж шалгаарай.</p>

<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн олон янзын хэлбэрээс бэлгийн хүчирхийлэл болон бие махбодын хүчирхийллийн тухай мэдээг илүү хөндөж, сэтгэл санааны, эдийн засгийн зэрэг хүчирхийллийн бусад хэлбэрийг үндсэндээ орхигдуулдаг (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Мөн сэтгүүлч, редакторууд жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт муутайгаасаа болж нүдэнд илт харагдахгүй хохирлыг багасгаж дүрслэх алдаа гаргах нь бий.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт сайтай байж, бие махбод болон сэтгэл санааны хохирлыг бодитоор дүрслэх шаардлагатай. Хүчирхийллийн хохирлыг ямар нэг байдлаар багасгаж ойлгуулахаас зайлсхийгээрэй. Тухайлбал, “Хохирогч бие махбодын ноцтой гэмтэл аваагүй байна” гэж бичсэн хэсэг байвал хасахаа мартаузай.</p>
--	---

Найруулга зүй, үг хэллэгийн хувьд анхаарах зүйлс

БУРУУ	ЗӨВ
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийг даван туулагчид нь хамаатуулан бичиж БОЛОХГҮЙ.</p> <p>Жишээ нь, Даван туулагчийн нэрийн хүчингийн хэрэг.</p> <p>Ингэж бичсэнээр жендэрт суурилсан хүчирхийллийг өртсөн хүнд нь хамаатуулж, хариуцлага хүлээх ёстой үйлдэгчийг нь дурдалгүй өнгөрдөг.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр өгүүлбэрээ найруулан бичээрэй.</p> <p>Жишээ нь, Хүчирхийлэгчийн нэрийн хүчингийн хэрэг.</p> <p>Хуулийн хүрээнд хэргийг шийдвэрлээгүй байгаа тохиолдолд “сэжигтэн”, “шүүгдэгч” гэх мэтээр бичих нь зүйтэй.</p>

<p>Даван туулагчийг үйл үгийн субъект болгон бичиж болохгүй. Ингэснээр хүчирхийлэгчийг хариуцлагаас зайлуулж харагдуулдаг.</p> <p>Жишээ нь, Хохирогч ажлын бус цагаар сэжигтний өрөөнд орж, улмаар хүчиндүүлжээ.</p>	<p>Хүчирхийлэгчийг өгүүлбэрийн субъект (өгүүлэгдэхүүн) байдлаар, үйл үгийг түүнд хамаатуулан бичих нь зүйтэй.</p> <p>Жишээ нь, Сэжигтэн хохирогчийг ажлын бус цагаа р өрөөнд нь орж ирэхийг албадаж, улмаар хүчинджээ.</p>
<p>Хэргийг зөөлрүүлэх, эсвэл ойлгомжгүй болгох нэршил ашиглах нь буруу.</p> <p>Тухайлбал, гэр бүлийн асуудал, эхнэр нөхрийн маргаан, амрагийн асуудал гэх мэт ойлгомжгүй, хуулийн хариуцлага хүлээлгэж болохооргүй үг хэллэг элбэг тохиолддог.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэл, хүчин зэргээр хуулийн хэллэгийг тодорхой, ойлгомжтой байдлаар ашиглаарай.</p>
<p>Үйлдлийг хэрхэн тодорхойлж байгаагаа анхаараарай. Заримдаа үг давтах алдаанаас зайлсхийхийн тулд хүчинг “бэлгийн харьцаа” гэж хольж сольж бичих алдаа гардаг. Зөвшөөрөлгүй бэлгийн харьцаанд орох, өдөх, оролдох гэх мэт тодорхойгүй, зөөлчилсэн хэл найруулга ашиглах нь буруу.</p>	<p>Бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, хүчиндэх зэргээр үйлдлийг тодорхой бичих нь зүйтэй бөгөөд үг давтах алдаанаас айх шаардлагагүй.</p>

Даван туулагчтай ярилцлага хийхдээ анхаарах зүйлс

Даван туулагчтай ярилцлага хийхдээ ямар нэгэн байдлаар хохирол учруулахгүйн тулд даван туулагч төвтэй арга зүйн зарчмуудаа эргэж харах нь зүйтэй.

Хэрхэн зөвшөөрөл авах вэ?

- Даван туулагч ярилцлага өгөхгүй байх эрхтэй. Хүчирхийллийг даван туулсан хүн сэтгэл санааны хямрал, цочролд орсон байдаг учраас ярилцлага өгөхөөс татгалзах, дурамжхан байх тохиолдол элбэг. Тийм үед ярилцлага өгөхийг ятгах, ухуулах хэрэггүй. Өөрийн зорилгыг танилцуулаад, холбоо барих мэдээллээ өгөөд л орхиорой. Шаардлагатай бол эх сурвалж өөрөө тантай холбоо барьж болно шүү дээ. Мөн хохирогчтой нүүр тулж ярилцахаас илүүтэй түүнд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн, сэтгэл зүйчээс мэдээлэл авах нь зохистой байж болно.
- Бүрэн мэдээлэл авсан зөвшөөрөл хүсээрэй. Даван туулагчаас авсан мэдээллээ хаана, хэзээ, ямар форматаар гаргах агуулгад ашиглах гэж байгааг сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй. Мөн энэ агуулгыг бэлтгэх хүрээнд өөр хэнтэй ярилцах, хүчирхийлэгчээс яриа авах эсэхээ мэдэгдээрэй. Ингэснээр даван туулагч ярилцлага өгөх эсэхээ шийдэхэд туслах болно. Хэрвээ та даван туулагчийн зураг, дүрсийг авна гэж төлөвлөж байгаа бол ярилцлагаасаа өмнө зөвшөөрөл авч, хэрхэн, яаж гаргааа урьдчилан тохиролцоорой. Даван туулагчийн түүхийг дараа нь өөр бүтээлдээ ашиглахаар болбол энэ тухайгаа мэдэгдэж, өөрөөс нь зөвшөөрөл авах шаардлагатай.

Ярилцлага хийхдээ юуг анхаарах вэ?

- Аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих. Даван туулагч болон түүний хүүхдүүд, ойр дотнын хүмүүс бие махбод болон сэтгэл санааны хохирол хүлээх аливаа эрсдэлийг нарийн тооцоолж бүх зүйлээ төлөвлөх хэрэгтэй. Үүнийг сэтгүүлчээс гадна ярилцлага хийх явцад оролцож буй хүн бүр (редактор, зураглаач, зурагчин, хэлмэрч, жолооч) ойлгосон байх нь чухал.
- Ярилцлагадаа хангалттай цаг төлөвлөх. Ярилцлага эхлэхээс өмнө ч даван туулагчид хангалттай мэдээлэл, ойлголт өгөх цаг гаргах хэрэгтэй. Зарим даван туулагч түүхээ ярих явцдаа сэтгэл нь үймэрч, хямарч мэдэх учраас сэтгэл засалч, эсвэл найз нөхөр нь хамт байх шаардлагатай бол тэр нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Ярилцлагын

явцад хэцүү асуулт асуухдаа яагаад тэр асуултыг асууж байгаагаа эвтэйхэн, ойлгомжтой тайлбарлаж өгөөрэй.

- Даван туулагчийг хүндэтгэх. Сэтгүүлчийн хувьд энэ нь эх сурвалжийнхаа хувийн нууц, хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэхийг хэлж байна. Даван туулагчийн сэтгэл санаанд нэмэлт дарамт болохуйц асуулт асуух, эсвэл үйлдэл хийхгүй байх нь чухал. Хүчирхийлэлд өртсөн хүн сэтгэл санааны хүнд дарамтад орсон байдаг учраас, мөн ихэнхдээ хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах туршлага багатай байдаг болохоор юу ярих, юу ярихгүйгээ мэдэхгүй байх, тулгамдах, сандрах тохиолдол бий. Мөн сэтгэлийг нь шархлуулсан түүхийг ярих нь амаргүй байх бөгөөд жендэрт суурилсан хүчирхийлэл нь маш эмзэг сэдэв гэдгийг санаарай. Энэ бүхэнд хүлээцтэй, ойлгох сэтгэлээр хандаж, даван туулагчийг өөрийнх нь эсрэг үйлдэгдсэн хүчирхийлэлд ямар нэг байдлаар буруутгах хандлага гаргахаас зайлсхийгээрэй.
- Мэдрэмжтэй байх. Таны хийж буй ярилцлага хүчирхийллийг даван туулсан хүний хэрэгцээ, шаардлагад нийцэж байна уу гэдгийг сайтар бодолцох хэрэгтэй. Олон улсын зарим байгууллагын зүгээс эмэгтэй хохирогчтой зөвхөн эмэгтэй сэтгүүлч л ярилцлага хийх нь зүйтэй гэж зөвлөдөг. Ямар ч байсан ярилцлага авч буй сэтгүүлч жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдлэгтэй байж, хохирогчийг буруутгах сэдэл төрүүлэхгүй байхад анхаарах нь чухал.
- Мэдрэмжгүй асуулт, үг хэллэг, тайлбараас зайлсхийгээрэй. “Хүчингийн хэрэг гарах үед та юу өмсч байсан бэ? Яагаад шөнө ганцаараа явж байсан бэ?” мэтийн асуултыг даван туулагчийг эвгүй байдалд оруулах, буруутгах байдлаар тавьж огт болохгүй. Тухайлбал, “Та энэ хэргийнхээ талаар цагдаад мэдэгдэхгүй яасан юм бэ?” гэхийн оронд “Цагдаад мэдэгдэх талаар бодож үзсэн үү, энэ алхмыг хийхэд тань юу саад болсон бэ?” гэж асуух нь тохиромжтой.

Ярилцлагын дараа юуг анхаарах вэ?

- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгчдөд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүдтэй холбоо барих мэдээллийг шаардлагатай бол эх сурвалждаа сануулаарай. Ийм мэдээлэл хангалттай байдаггүйгээс хохирогчид хаана, хэнд хандахаа мэддэггүй.
- Ярилцлага хийснийхээ дараа даван туулагчтай ярилцлагаа эргээд нэг дүгнэж, эргэлзэж байгаа, гаргахыг хүсээгүй мэдээлэл байгаа эсэхийг лавлаарай. Мөн редактортаа, эсвэл өөр хэн нэгэнд ярилцлагаа буулгасан хэлбэрээр үзүүлэхээсээ өмнө даван туулагчид өөрийнхөө яриаг эргэж харах боломж олгох нь зүйтэй.

- Ярилцлагаа буулгасныхаа дараа даван туулагч болон түүний үр хүүхдүүдэд эрсдэл учруулж болох мэдээлэл байгаа эсэхийг нягтлан шалгаарай. Даван туулагч хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах туршлагагүй хүн бол, эсвэл сэтгэл нь хөдөлсөндөө өөрийн болон ойр дотнын хүмүүсээ аюулд оруулж болох зүйлсийг ярих нь бий. Мэргэжлийн сэтгүүлч, редактор хүнийхээ хувьд та эх сурвалжийнхаа аюулгүй байдлыг дээд зэргээр бодож, эрсдэлтэй мэдээллийг хасахаа мартуузай.

Зураг, дүрс авах, сонгохдоо анхаарах нь

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ, сурвалжлагыг зурагжуулж, дүрсжүүлэхдээ юуны түрүүнд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын Дөрөвдүгээрт хэрхэн заасныг эргэж харах нь зүйтэй. Мөн даван туулагчийн зураг, дүрсийг гаргаж болох уу, болохоор бол ямар байдлаар гаргах вэ гэдэг зайлшгүй бодолцох асуудал. Энэ хүрээнд даван туулагч төвтэй арга зүйн зарчмуудаа заавал эргэж хараарай. Хэдийгээр олон улсын ихэнх байгууллага хүчирхийлэлд өртсөн хүний зураг, дүрсийг авах, олон нийтэд хүргэхийг зөвлөдөггүй ч даван туулагчтай өөртэй нь ярьж шийдэх нь зүйтэй.

Зураг, дүрс авах, сонгохдоо дараах зүйлсийг анхаараарай

· Ярилцлага хийхээр тохирох үедээ л зураг, дүрс авах боломж бий, эсэхийг лавлаарай. Даван туулагч өөрөө л хүсээгүй бол түүний болон түүнийг таниулж болох зураг, дүрс гаргах нь буруу. Эх сурвалж өөрөө зургаа гаргахыг хүслээ гэхэд гарч болох үр дагаврыг сайтар тайлбарлаж ойлгуулсаны үндсэн дээр зөвшөөрлийг нь албан ёсоор бичгээр аваарай. Ингэхдээ зураг, дүрсийг нэрээ нууцалсан, танигдуулахгүй байдлаар авах, эсэхийг мөн тодорхой ярилцаж тохирох хэрэгтэй.

- Хэрвээ даван туулагч нэрээ нууцлахыг хүсэж байгаа бол зураг, дүрсийг бүрэн танигдахааргүй болгох тал дээр маш сайн анхаараарай. Тухайлбал, зураг, дүрс аваад дараа нь бүдгэрүүлэх, бүрэлзүүлэх эффект оруулсан ч гэсэн тэрийг арилгаж харах боломжтой программ бий. Тиймээс зураг дүрсийг анхнаасаа л ар талаас талаас нь танигдахааргүйгээр, эсвэл бүдэг гэрэлтэй орчинд, хөшигний цаанаас авах гэх мэт арга хэрэглэж болно.

- Даван туулагчийг танигдуулах деталь мэдээлэл зураг, дүрсэнд орсон эсэхийг сайтар нягтлан шалгаарай. Тухайлбал, бэлгийн дарамтад өртсөн дунд сургуулийн сурагчийн тухай телевизээр мэдээлэхдээ нэрийг нь нууцалж, яриа өгсөн ээж, багшийнх нь царайг бүрэлзүүлсэн боловч сурвалжлагч яг сургуулийнх нь өмнө, нэр хаяг нь тодорхой харагдах байдлаар хөтөлж байв. Ингэснээр тухайн сурагчийн ангийнхан болон багш нар нь таних бүрэн боломжтой.
- Даван туулагчийн эрхэм чанарыг хүндэтгэх үүднээс зураг, дүрсийг ямар өнцгөөс хэрхэн авах вэ гэдгийг бодолцох шаардлагатай. Мөн зурагчин/зураглаач эргээд түүнтэй холбоо барьж, олон нийтэд хүргэх зураг/дүрсний сонголтоо хамт хийх нь зүгээр байдаг.
- Хэрвээ даван туулагч зураг, дүрсээ гаргахаас татгалзвал тэр сонголтыг нь хүндэтгэж үзэх ёстой. Жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвийг хөндөхдөө гар зураг ашиглах боломжтой. Ингэснээр асуудлын мөн чанарыг харуулах биш, дүрслэх боломж бүрддэг. Мөн ёс зүй, эрх зүйн олон асуудлыг тойрч гарах сайн талтай.
- Хэвшмэл ойлголтыг, эсвэл хохирогчийг буруутгах хандлагыг дэвэргэхүйц зураг дүрс гаргахаас болгоомжлоорой. Тухайлбал, согтууруулах ундаа хэрэглэж байгаа эмэгтэй хүний зураг гаргах нь хохирогчийг буруутгах сэдэл төрүүлнэ. Хоёр нүд нь хөхөрсөн, доошоо харсан эмэгтэйн зураг гаргах нь хүчирхийллийн хохирогч бие махбодын хувьд нүдэнд харагдахуйц гэмтэл авсан байдаг, эсвэл сул дорой эмэгтэй байдаг гэх хэвшмэл ойлголтыг дэвэргэнэ.

“Хөөрхөн зүрхнүүдийн аян” ТББ-аас өгч буй зөвлөмж

Бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч/даван туулагчидтай ярилцлага хийхдээ дараах зүйлсийг анхаарахыг хүсч байна. Үүнд:

- **Зөвшөөрөл авах:** Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчаас зөвшөөрөл авахдаа ирээдүйд гарч болзошгүй эрсдэл, тухайн ярилцлагын зорилго, давуу болон сул талыг маш сайн ойлгуулах
- **Итгэлт харилцааг бий болгох:** Ярилцлага хийхээс өмнө даван туулагчидтай итгэлт харилцааг бий болгосон байх. Тухайн хүн өөрийн хүссэн хурд, хэмнэлээр ярилцлага өгөх ёстой ба аливаа төрлийн тулган шаардлагад өртүүлэхгүй байхаас сэргийлж, анхаарч ажиллана гэдгээ урьдчилан ярилцах

- **Хохирогч/даван туулагчийг хүндэлж, ойлгож мэдрэх, эмпати байх:** Нинжин сэтгэлээр хүндэлж, ойлгож, мэдэрч ярилцах хэрэгтэй. Даван туулагч сэтгэцийн гэмтэл, цочролд өртсөн байх тул өөрийн түүхийг ярихгүй байх бүрэн эрхтэй. Үүнийг мөн тэдэнд сануулах
- **Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалыг ашиглах:** Ярилцах гэж буй сэдэв нь даван туулагчид дахин сэтгэцийн гэмтэл учруулж болзошгүй эрсдэл бүхий сэдэв гэдгийг сэтгүүлч мэддэг, үүнд мэдрэг ханддаг байх. Өөрийн үг хэллэг, хоолойны өнгө, биеийн хэлэмжид анхаарч даван туулагчид тухгүй, тааламжгүй мэдрэмж төрүүлэхээс аль болох зайлсхийх. Ярилцлага дундуур завсарлага авч, шаардлагатай үед сэтгэл зүйн тусламж авах боломжийг мөч бүрд хангаж улмаар ярилцлагыг зогсоох хүртэл арга хэмжээ авах
- **Ярилцагчийн нас, хөгжлийн түвшинд мэдрэг байх:** Ярилцлагын асуулт бэлдэхдээ хохирогч/даван туулагчийн нас, онцлогт тохирсон үг хэллэг болон биеийн хэлэмжид анхаарах. Бага насны хүүхэдтэй ярилцлага хийхдээ хүүхдийн асран хамгаалагч болон сэтгэл зүйчийг хамт байлцуулах
- **Хувь хүний орон зай болон нэрийг нууцлах:** Өөрийгөө олон нийтэд таниулахыг хүсээгүй тохиолдолд нэр, хаяг хийгээд хувь хүний орон зайг ямагт нууцлах. Ярилцлагыг олон нийтэд цацахаас өмнө нууцлалын хэм хэмжээг ярилцагч болон түүний асран хамгаалагчтай ярилцах, тохиролцох
- **Дахин хохирогч болохоос сэргийлэх:** Ярилцлагын аль нэг үйл явцад хохирогч/даван туулагчийг сэтгэл зүйн хувьд гэмтээх, буруутгах, гутаах, дахин хохирогч болгохоос сэргийлэн ажиллах. Сэтгэлийг нь сэрдхийлгэх, айлгасан, дахин сэтгэцийн гэмтэлд оруулах асуулт асуухаас зайлсхийх. Зөвхөн хүчирхийллийн үйл явдал дээр тулгуурлахгүйгээр хохирогч/даван туулагчийн давуу тал, сэтгэлийн хат, илаарших үйл явцад илүү анхаарах
- **Нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийг санал болгох:** Хууль эрх зүй, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээнүүдийн тусламжийн утас, хаягуудыг урьдчилан бэлдэж, ярилцагчид өгөх
- **Ёс зүй ба баримтуудыг хянан шалгах:** Хохирогч/даван туулагчийн нууцлалыг хадгалангаа баримтыг цуглуулахдаа мэргэжлийн ёс зүйг чандлан баримтлах. Тухайн мэдээллийг олон нийтэд цацсанаар хохирогч/даван туулагч болон тэдний гэр бүл, улмаар нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох

- **Ярилцлагын дараа дахин ярилцах:** Нэмэлт дэмжлэг хэрэгтэй эсэхийг тодруулах, хүүхэд болон тэдний гэр бүлийн байдлыг асуух. Шаардлагатай нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг санал болгох.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаарх мэдээллийг цацах зорилго нь хохирогч/даван туулагчийн дуу хоолойг олон нийтэд хүргэх, бэлгийн хүчирхийллийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх ба илаарших үйл явцыг дэмжих гэдгийг ямагт санаж ажиллах хэрэгтэй. Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн зорилгоос илүү хохирогч/даван туулагчийн аюулгүй байдал чухал гэдгийг ямагт анхаарч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө, зөвлөмж авч байхыг хүсээд хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дагуу эх сурвалжаа ямагт нягталж, буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломжийг олгож байх нь зүйтэйг дурдсан байна.

Хохирогч уу, даван туулагч уу?

Сүүлийн үед олон улсын байгууллагуудын зүгээс “хохирогч” биш, “даван туулагч” гэж ярьж, бичиж байхыг зөвлөж байгаа. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүнийг даван туулах чадвартай, идэвхтэй байдлаар дүрсэлдэг гэж үздэг. Харин “хохирогч” гэдэг нь тухайн хүнийг идэвхгүй, сөрөг байдлаар дүрсэлдэг хэмээн тайлбарладаг. Гэвч Монголд хуулийн хүрээнд хохирогч гэдэг үгийг ашиглаж хэвшсэн учраас “даван туулагч” гэдгийг олон улсын байгууллага, ТББ-ууд л ашиглаж байна.

Ярилцлага авах зөвшөөрлийн хуудасны загвар

_____ овогтой _____ миний
бие энэхүү ярилцлагыг хэвлэл мэдээллийн _____
байгууллагын _____ нэртэй сэтгүүлчид өгөхдөө миний
өгсөн мэдээллийг олон нийтэд нийтлэл/нэвтрүүлгийн хэлбэрээр хүргэхийг
ойлгож, хүлээн зөвшөөрч байна. Мэдээллийг олон нийтэд хүргэхдээ (дугуйлна
уу):

- А. Миний овог, нэрийг ил гаргах
- Б. Миний овог, нэр болон намайг танигдуулахуйц мэдээллийг нууцлах

Хэрэв овог, нэрийг нууцлах бол сэтгүүлчтэй ярьж, тохирсон нууц нэрийг энд
бичнэ үү:

Зураг, дүрс ашиглахдаа (дугуйлна уу):

- А. Миний зураг, дүрсийг ил гаргах
- Б. Миний болон намайг танигдуулахуйц зураг, дүрс гаргахгүй байх
- В. Зураг, дүрсийг өөр хэлбэрээр гаргах

Хэрэв зураг дүрсийг өөр хэлбэрээр гаргах бол сэтгүүлчтэй хэрхэн ярьж,
тохирсон талаар мэдээллийг энд бичнэ үү:

(энэ хэсэгт дүрсийг бүдгэрүүлэх, дуу хоолойг өөрчлөх, орлон тоглогч ашиглах
гэх мэт мэдээлэл оруулж болно)

Ярилцлагаар өгсөн мэдээлэл олон нийтэд хүрсний дараа гарч болох үр
дагавартай танилцсан бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрч байна.

Ярилцлага өгсөн _____ гарын үсэг

Энэхүү мэдээллийг олон нийтэд хүргэсний дараа гарч болох үр дагаврын
талаар эх сурвалждаа танилцуулсан бөгөөд ярьж тохирсныхоо дагуу эх
сурвалжаа хамгаалах ёс зүйн хариуцлагыг чандлан сахих болно.

Сэтгүүлч _____ гарын үсэг

Он ... сар ... өдөр ...

3
БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭНИЙ
ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЁС ЗҮЙТЭЙ АВАХ
ЗӨВЛӨМЖ



ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭНИЙ ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЁС ЗҮЙТЭЙ АВАХ ЗӨВЛӨМЖ

Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэргийг ёс зүйтэй сурвалжилдаг байх нь редакцын бодлогын тулгуур зарчмын нэг байх учиртай. Энэ чиглэлийн мэдээллийг дамжуулахдаа хохирогч, түүний ар гэр болоод уншигчийн сэтгэл зүйд ямар нөлөө үзүүлэхийг юун түрүүн бодолцож, мэдээ, сурвалжлага дахь үг хэллэг, гэрэл зураг, дүрс бичлэгийг ёс зүйн зохистой хэмжээнд баримтлах нь хожмын таагүй үр дагавраас урьдчилан сэргийлэх тустай. Цагдаагийн байгууллагаас ч ингэж сануулдаг.

Энэхүү зөвлөмж нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгахын зэрэгцээ сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахиж мөрдөх, Хэвлэл, мэдээллийн ёс зүйн зарчмын “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана” гэсэн дөрөвдүгээр зарчмын хэрэгжилтийг хангахад зориулагдсан болно.



Сэтгүүлчид гэмт хэргийн нөхцөл байдлын талаар олон нийтэд мэдээлэл хүргүүлэх, зарим тохиолдолд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр нотлох баримт болгон дүрс бичлэг, гэрэл зураг авсан тохиолдолд дараах байдлаар боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

Гэмт хэргийн мэдээний зураг ямар байвал зохистой вэ?

Сэтгүүлч гэмт хэргийн газар мэргэжлийнхээ давуу байдлыг ашиглаж хэт түрэмгий хандахгүй байх, хязгаарлалтын бүсийг давахгүй байх, шууд дүгнэлт хийсэн мэдээлэл цацахгүй байх, гэрэл зургаа ашиглахдаа шаардлагатай бол дүрсийг бүрсийлгэн сарниулах нь зүйтэй.

Зураг 1. Гэмт хэргийн нөхцөл байдлын ерөнхий гэрэл зураг

Гэмт хэргийн мэдээлэлд аль болох ерөнхий байдлыг дүрсэлсэн гэрэл зураг сонгох нь илүү тохиромжтой.



Зураг 2. Гэмт хэргийн газрын хагас нарийвчилсан зураг

Гэмт хэрэг, тэр дундаа ноцтой хэргийн мэдээлэлд хэтэрхий нарийвчлан харуулсан гэрэл зураг сонгохоос татгалзах. Үүний оронд хагас нарийвчилсан гэрэл зураг хавсаргах.



Зураг 3. Гэмт хэргийн газрын нарийвчилсан зураг

Гэмт хэргийн газрын нарийвчилсан гэрэл зургийг шаардлагатай бол хавсаргаж болох ч аль болох цөөн тоотой байх нь зохистой. Ингэхдээ зургийг хэсэгчлэн болон нийтэд нь бүрсийлгэн сарниулах шаардлагатай. Мөн өнгөт биш хар цагаан байж болно.



Зураг 4. Гэмт хэргийн нөхцөл байдлыг хөндлөнгөөс харуулсан зураг

Энэ тохиолдолд ... гэрэл зургийн планыг ашиглах тохиолдол элбэг байдаг. ?



Зураг 5. Гэмт хэргийн нөхцөл байдлыг хийсвэр хэлбэрээр дүрслэн харуулсан зураг

Гэмт хэргийн нөхцөл байдлыг шууд харуулсан гэрэл зураг нийтлэх нь эмзэг мэдрэмтгий хүмүүс, ялангуяа хохирогчийн ар гэрийнхний сэтгэл зүйд шууд нөлөөлж болзошгүй байдаг. Иймд хийсвэр зураг ашиглах нь илүү зохимжтой.




Хэвлэн нийтлэхэд зохисгүй гэрэл зураг

Хэвлэл мэдээллийн байгууллагууд гэмт хэргийн мэдээллийг олон нийтэд цацах үед дараах зүйлийг заавал анхаарах ёстой.

Зураг 1. Гэмт хэргийн хохирогчийн царайг шууд харуулсан гэрэл зургийг нийтлэхээс татгалзана

Учир нь, гэрчийн аюулгүй байдалтай шууд хамааралтай.



Зураг 2. Гэмт хэргийн ул мөрийг шууд харуулсан гэрэл зургийг нийтлэхээс татгалзана

Энэ нь өмнө сануулсанчлан хохирогч болоод уншигчийн сэтгэл зүйд шууд сөргөөр нөлөөлөх хор уршигтай.

**Зураг 3. Олон нийтэд айдас төрүүлэхүйц байдлыг харуулсан
гэрэл зургийг нийтлэхээс татгалзана**



Тэр дундаа онц ноцтой гэмт хэргийн мэдээллийг гэрэл зургийн хамт нийтлэх нь байж боломгүй үйлдэл юм. Их хэмжээний цус нөж, аллагын зэвсэг, хэрэг гарсан орчны деталь хэсэг зэргийг хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтэд харуулах нь ёс зүйн хувьд байж болохгүй.



ХҮҮХЭДТЭЙ ХОЛБООТОЙ
МЭДЭЭЛЛИЙГ СУРВАЛЖЛАХ
АРГА ЗҮЙ

ХҮҮХЭДТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ СУРВАЛЖЛАХ АРГА ЗҮЙ

НҮБ-ын Хүүхдийн сан, Европын Сэтгүүлчдийн холбоотой хамтран боловсруулсан ёс зүйн зарчмын онцлох заалтаас энэхүү гарын авлагад багтаалаа.

Сонирхуулахад энэхүү ёс зүйн зарчмыг боловсруулахад зөвхөн сэтгүүлч төдийгүй хуульч, хүүхдийн сэтгэл зүйч, PR менежер зэрэг мэргэжилтнүүд оролцсон нь хүүхдийн асуудлыг бичих нь зөвхөн сэтгүүлчдийн төдийгүй нийгмийн анхаарч үзэх, хариуцлагатай хандах зүйл гэдэг нь харагдана.

Сэтгэл хөдлөлдөө бүү авт

Хүүхэдтэй холбоотой мэдээлэл, тэр дундаа хүчирхийлэлтэй холбоотой хэргийг мэдээлэхэд магадгүй хамгийн их шаналдаг нь сэтгүүлчид болов уу. Тэр хэрээрээ эмзэглэж, тухайн асуудлыг судалж, аль болох шуурхай мэдээлэхийг хичээдэг. Гэхдээ түр азнаарай.

Та хэдийгээр мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг, итгэж болох мэдээллийн эх сурвалжтай ч доорх асуултыг өөрөөсөө заавал асуугаад үзээрэй.

Асуулт:



- **Би сэтгэл хөдлөлдөө хэт автаад байгаа юм биш биз?**
- **Контентын агуулга олон жилийн дараа ч гэсэн тухайн хүүхдэд ичсэн, таагүй мэдрэмж төрүүлсээр байх юм биш биз?**

Хүүхдийн дүр төрх, яриа цахим ертөнцөд үлдсэнээр түүний амьдралын түүхэнд “хар тамга” дарж, ирээдүйд гутаан доромжлогдох, ялгаварлан гадуурхагдах шалтгаан ч болж мэднэ.

Дата өгөгдлөөс хамаарч хэний ч хувь тавилан өөрчлөгдөж мэдэх энэ зуунд бид үүнийг дахин нэг эргэцүүлж, шаардлагатай тохиолдолд нийтлэхгүй байх хүн ёсны сонголт танд бий.

Асран хамгаалагчийн зөвшөөрөл авсан ч дахин нэг удаа тунгаах асуулт

Хүн бүхэнд хувь хүний нууц, нэр төр гэж бий. Асран хамгаалагч нь хүүхдээс ярилцлага авч, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг ил гаргахыг зөвшөөрсөн байж болно.

Та өөрөө ч мэдээллийн эх сурвалжаа хангалттай судалж нягт нямбай хандсан байж болно. Гэсэн хэдий ч өөрөөсөө дараах асуултыг асуухад илүүдэхгүй.

Асуулт:



- Хувийн мэдээллийг задруулах нь тухайн хүүхдийн ирээдүйд сэргээр нөлөөлөх боломжтой юу?

Алдаа оноотой амьдрах боломжийг нь үлдээхийн тулд анхаарч үзэх ёстой хэд хэдэн зүйл бий. Энэ нь хохирогчийн оршин суугаа хаяг, сургууль, нас зэрэг ерөнхий мэдээлэл болон ямар нэгэн байдлаар танигдахуйц мэдээлэлд хянамгай хандах явдал юм.

Ярилцлага авахдаа хохирогчийн дүр төрхийг нууцалж байгаа ч дуу хоолойг нь өөрчлөхөөс эхлээд жижиг мэт харагдах зүйлсийг ч анхаарч үзэх ёстой.

Энэ мэтийн алдаанаас болж хохирогч танигдаж, эргээд хэвийн амьдралдаа ороход саад болж байгааг ХЭҮК тайландаа бичжээ.

Редакцын бодлогодоо тусгах нь

Олон улсад хүүхдийн асуудлыг сурвалжлахад ашигладаг маш нарийн ёс зүйн зарчмууд бий.

Хүүхдийн тухай бичиж, сурвалжлан бичих гарын авлага ховор. Тиймээс дараах гарын авлага, ёс зүйн зарчмуудыг өдөр тутамдаа ашиглахыг санал болгож байна.

- Олон улсын зарчим, ёс зүйн хэм хэмжээнээс суралцах
- ХМЗ-ийн Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баримтлах
- Редакц хүүхдийн асуудлыг сурвалжлах арга зүйгээ тодорхой болгох



Хохирогчийн сэтгэл зүйг дахин хохироох ёсгүй

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороонд 2019 онд нэгэн гомдол ирсэн нь Сэлэнгэ аймагт алга болсон есөн настай охины тухай мэдээлэл байв. Алга болсон охины талаарх мэдээллийг нэр бүхий долоон сайт нийтлэхдээ алга болсон охины тухай мэдээлэл олон хүмүүст хүрч, аль болох түргэн олдоход тус нэмэр болох сэтгэлээр нийтэлсэн боловч үр хүүхдээ алдаад сэтгэл санаа хэцүү байгаа хохирогчийн хувьд охины нэр, нас, гэрэл зураг, амьдардаг хашааны зургуудыг нийтэлсэнд эмзэглэж гомдол гаргасан юм. Хохирогчид хүндэтгэлтэй хандаагүй энэ гомдол нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад сургамж болохоор тохиолдол байв.

Хэвлэл мэдээллийн байгууллага хохирогчийг нэмж хохироох, сэтгэл зүйн хувьд дарамт болохоос сэргийлэх ёстой.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд 2023 оны аравдугаар сард Дорноговь аймагт алга болж, улмаар амь насаа алдсан охины хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан этгээдийн талаар мэдээлэхдээ хэдэн жилийн өмнө алга болсон Сэржмядаг охины хэрэгт холбоотой байж магад хэмээн хэвлэлүүд зургийг нь тавьж нийтэлсэнд Сэржмядаг охины ээж гомдолтой байгаагаа олон нийтэд илэрхийлсэн. Хэдэн жилийн өмнө алга болсон охиных нь зургийг алуурчин хэмээн сэжиглэгдэж буй хүний зурагтай зэрэгцүүлэн

түгээсэнд сэтгэл нь шархалсан. Хохирогчийн сэтгэл зүй ийм эмзэг байдаг гэдгийг харгалзан үзэх ёстой.

Хэдийгээр бид мэргэжлийн ёс зүйн код, сэтгүүлчийн ёс зүйн зарчим гэж янз бүрээр нэрлэдэг ч энэ нь үнэндээ асуудалд хүн ёсоор асуудалд хандах тухай л билээ.

Харилцаа холбооны зохицуулах хороо /ХХЗХ/-ноос гаргасан хүүхдийн тухай мэдээлж, сурвалжлахдаа анхаарах зөвлөмж

Орчин цагийн амьдралын бараг бүхий л асуудал цахим ертөнцтэй салшгүй холбогдсон билээ. Бидний ярьж заншсанаар Z үеийнхэн интернэттэй хамт өсч, тэдний ихэнх нь хөдөлгөөнт холбооны системээр холбогдож байна.

ХХЗХ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилладаг.

Тус хорооноос 2020 онд хийсэн Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгаанд:

- Монгол Улсын 13-18 насны хүүхдийн 96 хувь нь интернэт хэрэглэдэг бөгөөд интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютуб зэрэг сошиал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр холбогдож тоглоом тоглох зэрэг нь чамд аюул учруулна гэж боддог эсэх талаар тодруулахад, 24% нь ямар ч аюулгүй, 41% нь бага зэргийн аюултай байж магадгүй буюу 10 хүүхэд тутмын 6-7 нь аюулгүй гэж үзсэн байна.
- Харин 26% нь ер нь бол аюултай, зөвхөн 7% нь маш аюултай, үлдсэн 2% нь хэлж мэдэхгүй буюу 10 хүүхэд тутмын 3-4 нь интернэт орчныг аюултай гэж үзэж байгаагаас харахад энэ талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа тул хүүхдийг цахим орчинд аюулгүй байлгахад хэвлэл мэдээллийн салбарын үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс гаргаж буй энэхүү гарын авлагад цахим орчинд мэдээлж, сурвалжлахад хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаарх дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, эрхийг ямар ч нөхцөлд хүндэтгэх;



Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгаа



2. Хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа нийтлэхгүй, түгээхгүй, ашиглахгүй, хуваалцахгүй байх;
3. Хүүхдэд садар самуун, мөрийтэй тоглоом, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа сурталчилсан болон оролцуулсан мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа бэлтгэхгүй, мөн түгээхгүй байх;
4. Зохиогчийн эрхийн зөрчил болон аливаа хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг сурталчлахгүй байх;
5. Хүүхдийн нийгмийн сүлжээ /Facebook, Instagram, Tik Tok гм/-ний хаяг, цахим шуудангийн хаяг зэрэг хувийн мэдээллийг нийтлэхгүй, хуваалцахгүй байх;
6. Цахим орчинд хүүхдийг бэлгийн хүчирхийллийн зорилгоор дүрсэлсэн зураг, бичлэгийг ХХЗХ-ны www.ekids.mn веб сайтаар дамжуулан Internet Watch Foundation (IWF)-д мэдээлж устгуулах хүсэлт гаргах, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх;
7. Хүүхдийг оролцуулсан контент бүтээхдээ эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас бичгээр зөвшөөрөл авах;
8. Хүүхдийн зураг авах, дүрс бичлэгт оролцуулах, мэдээ мэдээлэл, зар сурталчилгаанд оролцуулахдаа дараах мэдээллийг оруулахгүй байх:
 - 8.1. Хүүхдийн овог, нэр /зөвшөөрөл авах/;

- 8.2. Хүүхдийн сургуулийн нэр, анги бүхий мэдээлэл агуулсан энгэрийн тэмдэг;
 - 8.3. Сурдаг сургууль, сургалт, дамжааны талаарх мэдээлэл;
 - 8.4. Хүүхдийн байгаа газар зүйн байршлын мэдээлэл;
 - 8.5. Хүүхдийн биеийн нууц, далд хэсгийг харуулсан хэсэг;
 - 8.6. Бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдлаар дүрслэн харуулсан;
 - 8.7. Эрүүл мэндийн байдал, биеийн өгөгдөл, өндөр, жин зэрэг мэдээлэл;
 - 8.8. Хүүхдийг зохисгүй байдлаар дүрсэлсэн;
 - 8.9. Гамшиг, ослын үеийн эмзэг байдлаар дүрслэн харуулахгүй байх;
 - 8.10. Уур уцаар эсвэл таагүй ааш занг харуулсан;
 - 8.11. Хүүхдийг хөөрхийлөлтэй, хохирогч, эмзэг байдлаар дүрслэн харуулсан;
 - 8.12. Хүүхдийг бэлгийн болон бусад хүчирхийллийн хохирогч, халтар хувцастай гэх мэт эмзэг байдлаар харуулсан.
9. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх.
 10. Эцэг, эхчүүд болон хууль ёсны асран хамгаалагчийн нийтэлсэн хүүхдийн зураг, бичлэг, мэдээ мэдээллийг зөвшөөрөлгүй авч ашиглахгүй байх.
 11. Хүүхдийн бусадтай харилцсан чат, эмзэг мэдээллийг олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, ашиглахгүй, түгээхгүй, дамжуулахгүй байх.
 12. Цахим орчинд бусдыг дарамтлах, дээрэлхэх зэрэг цахим гадуурхал үүсгэхгүй, дэмжихгүй, сурталчлахгүй, цахим гадуурхалд уриалан дуудахгүй байх.
 13. Хүүхдийг цахим орчинд бэлгийн хүчирхийлэлд хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, цахим орчинг ашиглан хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд уруу татах, холбоо тогтоохгүй, хүүхдийн эмзэг зураг, бичлэгийг ашиглахгүй, дамжуулахгүй байх.
 14. Цахим орчинд зөв зохистой ашиглах, цахим соёлыг түгээх, цахим орчинд эерэг, соёлтой байх.



СОГТУУРУУЛАХ УНДАА БОЛОН
ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ТУХАЙ
СУРВАЛЖЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧМЫН ДӨРӨВДҮГЭЭР ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгч Сокорро Эскаланте “Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь нийгмийн эрүүл мэндийн хувьд томоохон асуудал бөгөөд дэлхий даяар үүнээс шалтгаалан гурван сая хүн нас барж, олон сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болж, эрүүл мэндийн доройтолд орж байна” гээд дэлхий нийтэд өвчлөлийн 5.1 хувь нь архинаас шууд хамааралтай гэсэн судалгаа гарсныг хэлж байлаа. Монгол Улсад 270 хүн тутамд архи, согтууруулах ундаа борлуулах нэг цэг ногдож байгаа нь дэлхийд маш дээгүүрт орох үзүүлэлт” хэмээн 2023 оны аравдугаар сард болсон “Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах нь” салбар дундын хэлэлцүүлгийн үеэр хэлснийг GoGo.mn сайт нийтэлжээ.

Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг сурвалжлахад архи, согтууруулах ундааны сөрөг талыг олон нийтэд ойлгуулах нь архинаас хамааралтай гэмт хэргийг буруулахад эерэг нөлөөтэй юм. Ялангуяа, өсвөр үе, залуучуудад архи, согтууруулах ундааны хор уршгийг таниулан сурталчлахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл манлайлан ажиллах хэрэгтэй байна.



ДЭМБ-аас гаргасан зөвлөмж

Архи, согтууруулах ундаа нийгэмд ямар хор уршигтай вэ?

Архи, согтууруулах ундаа нь төв мэдрэлийн тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Үүнээс шалтгаалан согтуурсан хүн нь эргэн тойронд байгаа хүмүүс, гэр бүлийн гишүүд, хамаатан садан, найз нөхөд, хамт ажиллагсад эсвэл гудамжинд тааралдсан хүнийг ч санаатай болон санамсаргүйгээр гэмтээх эрсдэлт хүчин зүйл болдог.

Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүний нийгэмд учруулах хохирлыг эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн хэмээн ангилж болно. Тухайлбал,

Эрүүл мэндийн хувьд: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон осол хийж өөрийн болон бусдын эрүүл мэндийг хохироох, амиа хорлох, бусдын амь насыг бүрэлгэх, согтууруулах ундааны хордлогод орох, гэр бүлийн гишүүдээ

түгшүүр, сэтгэл гутралд автуулах, санамсаргүй бэлгийн харилцаанд орох, улмаар халдвар авах, дамжуулах эрсдэлтэй


Нийгмийн: Халдлагад өртөх, бусдад саад, төвөг учруулах

Эдийн засгийн: Ажлын гүйцэтгэл, бүтээмж буурах, ажил тасалдах, эд хөрөнгөд хохирол учруулах, гэр бүлийн хэрэглээнд зарцуулах мөнгийг архинд зарцуулах зэрэг

Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний нийгэмд үзүүлж буй хор хөнөөлийн цар хүрээ бүрэн тодорхойгүй ч хэд хэдэн судалгаагаар хор хөнөөлийг үнэлсэн байдаг. Австрали, Чили, Шинэ Зеландад хийсэн судалгаагаар хүмүүс архийг хэтрүүлэн уух нь эргэн тойрныхоо хүмүүсийн эрүүл мэнд, амар тайван байдалд сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоожээ.

Европын холбооны судалгаагаар (гол төлөв согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хүн амины хэрэг, ургийн архины синдром зэрэгт үндэслэсэн) нас баралтын нийт тохиолдлын 3-4% нь архины зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй гэжээ.

Архидан согтуурахтай холбоотойгоор нийгэмд учрах хохирлын ангилал:



Согтууруулах ундаанд донтох нь нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй үр дагавартай байх нь бий. Худалдан авах чадвар муутай, орлого багатай хэсэгт архины хэрэглээ нь нийгмийн бусад бүлгээс илүүтэй эдийн засгийн хувьд хохиролтой байж, өрхийн орлогод шууд нөлөөлдөг.

“Архины хор хөнөөлийн парадокс” гэж нэрлэгддэг судалгаагаар орлого багатай хүмүүс архи бага хэрэглэдэг ч чинээлэг хүмүүсээс илүү архины хор хөнөөлд нэрвэгдэх хандлагатай байдаг гэжээ.

Түүнчлэн архины зохисгүй хэрэглээний хор уршиг үе дамжих магадлалтай учир ядуурлын гинжин тойрог үүсгэх хорт үр дагавартай.

НҮБ-аас баталсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтуудын биелэлтийн гол хэмжигдэхүүнүүд болох эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудад архины зохисгүй хэрэглээ нөлөөлж байна. Тухайлбал, Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 13-д нь хамаарах нийт 52 зорилгод хүрэх боломжид сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь юун түрүүн эх, хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчин (ХДХВ, вируст гепатит, сүрьеэ), ХБӨ, сэтгэцийн эрүүл мэнд, зам тээврийн осол гэмтэл зэрэг Тогтвортой хөгжлийн зорилтуудын эрүүл мэндтэй холбоотой олон зорилгод шууд нөлөөлдөг.

Тогтвортой хөгжлийн зорилтуудын “Мансууруулах бодис, согтууруулах ундааны хор хөнөөлтэй хэрэглээг багтаасан мансуурлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх ажлыг бэхжүүлэх” хэмээн тодорхой зорилт дэвшүүлсэн (SDG 3.5:) нь дэлхийн хөгжлийн хөтөлбөрт согтууруулах ундаа зохистой хэрэглээ чухал үүрэгтэй болохыг харуулж байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлбэл, ялангуяа татвар, хүртээмжийн хяналт, зар сурталчилгааны зохицуулалттай холбоотой өргөн хүрээний бодлого нь архинд донтогчдын нийгэмд учруулж буй хор хөнөөл, эрүүл мэндийн асуудлыг бууруулаад зогсохгүй архинд өртсөн хүмүүсийг хамгаалж, туслах болно.

Гол өнцгийг олох

Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ бүрийн ард хүний амьдрал, түүх бий. Тиймээс архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний хор хөнөөлийн талаар бичих гэж байгаа бол хувь хүний амьдрал, нийгэмд үзүүлэх хор уршиг, учирч болох нөлөөллийг бүрэн тайлбарласан бүтээлийн түүх, өнцгийг олоорой.

Хор хөнөөл, уршигийг байнга хэлж, тайлбарлаж өг

Амьдралын хэв маяг, эсвэл бизнесийн үүднээс ч гэсэн согтууруулах ундааны хэрэглээ нь аюултай гэдгийг үргэлж мэдээлж байх хэрэгтэй. Тухайлбал, сэтгэцийн эрүүл мэнд, хорт хавдар, зүрхний өвчин, цус харвалт,

элэгний өвчин, хоол боловсруулах эрхтний эмгэгт хүргэж болзошгүйг хэлж, тайлбарлаж өгч болно.

Нотлох баримтыг ашигла

Согтууруулах ундааны хор хөнөөлийн талаар шинжлэх ухааны судалгаа, эрдэмтэн, эмч нарын мэргэжлийн шүүмжийг эх сурвалжаа болго.

Болзошгүй зөрчил, талуудын ашиг сонирхлын талаар санаарай

Согтууруулах ундаа үйлдвэрлэгчид, худалдан борлуулдаг байгууллагууд, тэдгээрийн санхүүжилттэй сэтгүүл зүйн шагналууд, зар сурталчилгаа, тэдний мэдэлд байдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, судалгааны төвүүдийн байр суурь мэдээлэл ашиг сонирхлын зөрчилтэй байж болохыг санаарай. Тэдний байр суурь, өгсөн мэдээлэл таныг төөрөгдөлд оруулж, бодит мэдээллээс холдуулах аюултай тул өөр бусад эх сурвалжийн мэдээллээр баталгаажуулаарай.

Зохимжтой үгсийг ашиглаарай

Хэн нэгнийг гадуурхсан, доромжилсон үг хэрэглэхээс зайлсхий. Хэн нэгэн хүний архины хэрэглээний талаар бичихдээ хувь хүний ёс суртахуун, зан байдал, нөхцөл байдлыг харгалзан үзэхээс гадна зар сурталчилгаа, арилжааны нөлөө зэрэг нийгмийн хүчин зүйлийг дурдахгүй өнгөрч болохгүй юм.

Хэн нэгнийг “архичин” гэж хэлж, бичих нь сөрөг ойлголтыг далд хэлбэрээр бий болгодог. Тиймээс “Архинд донтох эмгэгтэй хүн” гэсэн үгийг ашиглах нь илүү зохистой.

Хэрэгцээтэй мэдээллийг нь өгөөрэй

Согтууруулах ундаанд донтсон, улмаар сэтгэл санааны хямралд орсон хүмүүст зориулсан зөвлөмж мэдээллийг өгч байгаарай. Тухайлбал, архины донтолтыг эмчлэх орон нутгийн төвүүдэд хэрхэн хандах, холбогдох утсыг мэдээндээ оруулж болно. Зөвхөн архинд донтсон хүмүүсээс гадна тэдний гэр бүлийнхэн, найз нөхөд, эргэн тойрныхонд ч энэ мэдээлэл хэрэгтэй байж болно.



Электрон тамхины талаар бичих нь

ОНЦЛОХ ТАВАН БАРИМТ

Олон улсын нэршил: Шингэн зүйлийг халаан, уурыг нь сорж амьсгалд оруулахыг электрон тамхи татах гэнэ. Электрон тамхийг анх 2003 онд Хятадад үйлдвэрлэж эхэлсэн. Варог буюу уур гэдэг англи үгнээс гаралтай бөгөөд электрон тамхийг вэйп (vape), татахыг нь вэйпинг (vaping) гэж нэрлэх болсон.

Хэрэглээ: Дэлхий дахинд электрон тамхи татагчдын тоо 2020 онд 68 сая байсан бол 2021 онд 82 сая болж, нэг жилийн дотор 16 саяар нэмэгджээ.

Монгол улс сүүлийн 2-3 жилийн хугацаанд электрон тамхийг аливаа хяналтгүйгээр хилээр оруулж ирж байна. Импортын хэмжээ 2020 онтой харьцуулахад 2023 онд 1000 дахин өсч, 2 сая ширхэгт хүрчээ. Манай улсын 13-15 насны сурагчдын 3.5% нь электрон тамхи хэрэглэдэг гэсэн судалгаа бий.

Найрлага: Электрон тамхины шингэний найрлагад глицерин, пропилен гликол, үнэр оруулагч зэрэг химийн бодис байдаг. Эдгээрийг халаах үеэр формальдегид, ацетальдегид, акролеин болон глиоксаль зэрэг бодис ялгарч, үнэртүүлэгчтэй холилдсоноор тэдгээр нь таатай амт, үнэр үүсгэдэг боловч уушгинд сөргөөр нөлөөлдөг байна. Электрон тамхин дахь никотины дундаж агууламж яг энгийн тамхитай адил 14,5 мг хүртэл байдаг байна.

Бусад орны эрх зүйн зохицуулалт: Электрон тамхи татагчдын нас залуужиж, хэрэглээ хүүхэд, залуусын дунд ихэсч, онлайн худалдаа, сурталчилгааны хяналтгүй орон зай бий болж байгаатай холбогдуулан, хэрэглээг хязгаарлах, эрүүл мэндийн эрсдлийг багасгах зорилгоор [БНСУ, БНЭУ, Сингапур, Мексик, Бразил, Норвеги, Панам, Тайланд тэргүүтэй 30 гаруй улс эрх зүйн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.](#) Монгол улсын хувьд 19 нас хүрсэн хүнд иргэний үнэмлэх шалгаж худалдаална гэдэг ч хэн, яаж хяналт тавих эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй юм.

Хор уршиг: Тамхи л бол тамхи. Энэ нь хэлбэр дүрс, үнэр, амтаараа утаат тамхинаас ялгарах хэдий ч хүнд металлууд болон никотин (донтуулагч бодис) агуулдагаараа адил юм. Хүний биед ууршиж орсноор юун түрүүнд уушгийг гэмтээж, дараа нь тархины хөгжлийг удаашруулан, хавдар үүсгэх эрсдлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн дам тамхидалт буюу хөндлөнгийн хүмүүст илүү аюултай юм.



Электрон тамхины тухай хэрхэн ёс зүйтэй бичих зөвлөмж

Сэтгүүлчид нийгэмд болон хувь хүнд учруулах аливаа хор хөнөөлийн талаар олон нийтэд мэдээлэхдээ тухайн сэдвийн төдийгүй мэдээлэл хүргэх зорилтот бүлгийн онцлогийг харгалзан, мэдрэмжтэй, мэргэжлийн ёс зүйтэй хандах нь чухал.

Бидний ирээдүй болсон хүүхэд, залуусын дунд зан үйлийн болон эрүүл мэндийн бодит эрсдлийг дагуулж буй нэг зүйл нь электрон тамхи юм. Энэ сэдвээр бичихдээ анхаарах дараах зөвлөмжийг хүргэж байна.

ТОДОРХОЙ МЭДЭЭЛ

Эрүүл мэндийн сэдвийн мэдээнд ямар нэг “гоёл чимэглэл” хэрэггүй. Шинжлэх ухаанч, бодит, тэнцвэртэй гэсэн зарчмыг баримтлан, хэлэх гэсэн санаагаа тодорхой, шууд илэрхийл. Аль өнцгөөс мэдээлэхээс хамаарч ямар эх сурвалжаас баримт цуглуулах болон зорилтот бүлэг хэн байх нь тодорхой болдог. Нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулж байгаа тухай хөндөж байгаа бол хор уршгийг нь шууд хэлж өгөх хэрэгтэй.

ТӨӨРӨГДЛИЙГ АРИЛГА

Электрон тамхийг утаат тамхиа хаях гэж байгаа хүмүүст зориулан үйлдвэрлэдэг, хор хөнөөл багатай гэсэн буруу ойлголт, мэдээлэл олон нийтийн дунд түгээмэл байдаг. Энэ ташаа ойлголтод сэтгүүлч соргог хандан, үнэн бодитой, мэргэжлийн эх сурвалжаас авсан мэдээллээр уг төөрөгдлийг залруулах ёстой. Тухайлбал, электрон тамхи нь уламжлалт тамхинаас ялгаагүй никотин болон хорт хавдар үүсгэдэг химийн хорт бодисууд агуулдаг болохыг эрүүл мэндийн байгууллагын албан ёсны судалгаагаар бататга. Жишээ нь, “ДЭМБ-ын тайланд дурдсанаар электрон тамхийг хоргүй гэж үзэж болохгүй бөгөөд эмч нар тамхинаас гарах гэж байгаа хүмүүст зөвлөж болохгүй гэсэн байна” гэх зэргээр мэдээл. Мөн холбогдох чиглэлийн судалгааны нэр хүндтэй байгууллагаас гаргасан тоо баримтаар баяжуулан, мэргэжлийн эмчийн, эсвэл судлаачийн яриагаар хүргэж болно.

НЭГ НЭРШЛИЙГ АШИГЛА

Сэтгүүл зүйд үг давтах найруулгын алдаа гаргахгүйн тулд утгыг (жишээ нь, ихэнх, олонх, дийлэнх гэх мэт) өөр үг, нэршил хэрэглэдэг хэдий ч эрүүл мэндийн сэдэв нь хариуцлагатай, эмзэг учир няхуур хандах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан болон анагаах ухааны нэр томъёог хүлээн зөвшөөрөгдсөн нэг л нэршлээр хүргэх нь олон нийтийг төөрөлдүүлэхгүй байх ач холбогдолтой. Тухайлбал, электрон тамхийг цахилгаан тамхи гээд бичвэл зарим уншигч, үзэгч, сонсогчийг төөрөгдүүлж магадгүй.

ТОО БАРИМТЫГ ХӨРВҮҮЛ

Хэт их, эсвэл хоорондоо хамааралгүй тоо баримт мэдээллийн үр нөлөөг бууруулдаг талтай. Тиймээс эхнээсээ баримтаа зөв сонгож, баримтаа олон нийтийн мэддэг зүйлд нь хөрвүүлэн жиших арга нь илүү ач холбогдолтой. Жишээ нь;

- Электрон тамхи татах нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх төдийгүй эдийн засагт дарамт учруулдаг болох;
- Тамхи таталгүй 1 жил болж, тамхинд зарцуулах байсан мөнгөө хуримтлуулбал нөүтбүүктэй болох;
- Тамхи таталгүй 5 жил болбол хэмнэсэн мөнгөөрөө гэр бүлээрээ гадаадын улс оронд аялах;
- Тамхи таталгүй 10 жил болбол хэмнэсэн мөнгөөрөө машин худалдан авах;
- Тамхи таталгүй 20 жил болбол хэмнэсэн мөнгөөрөө орон сууцтай болох боломжтой гэж бичвэл тамхинаас гарах шууд сэдэл, урам зориг төрүүлж чадна.

НОТОЛГООНД СУУРИЛ

Хэлэх гэсэн санаа болгоноо баримтаар нотол. Ингэхдээ баримтын уялдаа холбоо, учир шалтгааныг зөв гаргах нь сэтгүүлчийн ур чадвар юм. Электрон тамхины хор хөнөөлийн талаар бичихдээ шинжлэх ухааны, эрүүл мэндийн, хөндлөнгийн судалгааны, эх сурвалжийн (эмч, эмнэлгийн байгууллага) зэрэг олон талын баримт нотолгоонд суурил. Хэзээ ч таамгаар бүү бич.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛД НЯХУУР ХАНД

Ашиг сонирхлын зөрчил хаана гарч болохыг урьдчилж тооцоол. Үйлдвэрлэгчид электрон тамхи нь уламжлалт тамхины хамаарлыг бууруулахад нөлөөлж, эрүүл мэндэд учруулах хор хохирол харьцангуй бага гэж сурталчилдаг ч шинжлэх ухааны судалгаагаар үүнийг нотолсон зүйл байхгүй юм. Үүний эсрэгээр электрон тамхи хортой юм бол уламжлалт тамхи татах нь зөв сонголт гэсэн ойлголтыг ч мөн өөгшүүлж болохгүй. Явцуу эрх ашигт нийцсэн эдгээр мэдээллийн цаана үйлдвэрлэгчдийн ашиг

сонирхол явж байдгийг ямагт санах хэрэгтэй. Талуудыг хамгаалахгүй, бас эрх ашгийг хөндөхгүйгээр аль ч тамхи аюул, эрсдэл дагуулдаг гэдэг нь л нийгэмд хүргэх гол мэссэж юм.

УЛИГ БОЛОХООС ЗАЙЛСХИЙ

Нэгэн хэвийн, байдаг л зүйлийг хэн ч үл ойшоодог. Урд өмнө нь мэдээлж байсан тоо, баримт, статистик мэдээлэл, судалгаан дээр бүтээлчээр ажилла. Хэний ч хөндөөгүй өнцөг, эсвэл хүн бүр мэддэг гэж боддог ч огт мэддэггүй зүйлийг барьж ав. Тухайлбал, электрон тамхи татаж буй хүнд гэхээсээ илүү түүний ойр тойрныхонд нь эрүүл мэндийн ямар аюул, занал учруулж болох вэ гэдгийг хөнд. Эсвэл бэлгийн сулралд хүргэдэг, амиа хорлох сэдэлд нөлөөлдөг, тархины хөгжлийг сааруулдаг гэх зэргээр хөндөгдсөн өнцөг болгондоо ач холбогдол өг”. Аль болох богино бичиж, дуустал нь уншуул.



Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим

Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

1

Ёс зүйн зарчмууд

Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

1.1

Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.

1.2

Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ.

1.3

Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, эшлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.

1.4

Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй.

1.5

Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.

1.6

Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана.

1.7

Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцийн агуулгаас ялгаж тэмдэглэнэ.

1.8

Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.

1.9

Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.

2

Ёс зүйн зарчмууд

Мэдээллийг шударга
бус аргаар олж
авахгүй.

2.1

Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно.

2.2

Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг худал хэлэх буюу хэлэхгүй байх, дарамтлах, айлган сүрдүүлэх, сэтгэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон тагнаж чагнахыг хамаатуулна.

2.3

Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

2.4

Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна.

2.5

Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.

3

Ёс зүйн зарчмууд

Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.

3.1

Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ.

3.2

Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.

4

Ёс зүйн зарчмууд

Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.

4.1

Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.

4.2

Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.

4.3

Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.

4.4

Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.

4.5

Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.

4.6

Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.

5

Ёс зүйн зарчмууд

Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.

5.1

Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.

6

Ёс зүйн зарчмууд

Хувийн нууцад
хүндэтгэлтэй
хандана.

6.1

Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.

6.2

Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.

6.3

Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.

6.4

Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.

6.5

Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.

6.6

Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.

6.7

Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.

6.6

Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.

7

Ёс зүйн зарчмууд

Бусдын уй гашуу,
зовлон шаналалд
хүндэтгэлтэй
хандана.

8

Ёс зүйн зарчмууд

Мэдээллийн нууц эх
сувалжаа чандлан
хамгаална.

9

Ёс зүйн зарчмууд

Төлбөрт нийтлэл,
нэвтрүүлгийг тусгай
тэмдэг, тэмдэглэгээгээр
ялгана.

9.1

Далд зар сурталчилгааны аливаа
хэлбэрээс татгалзана.

10

Ёс зүйн зарчмууд

Хэвлэл мэдээлэл
нь сонгуулийн
санал хураалтаас
өмнө буруутгагдсан
этгээдийг тайлбар хийх
боломжгүй хугацаанд
нэр дэвшигчийн талаар
мэдээлэл түгээхээс
зайлсхийнэ.